



Олон Улсын
Хөдөлмөрийн
Байгууллага



МОНГОЛ УЛСЫН
ХҮНИЙ ЭРХИЙН
ҮНДЭСНИЙ КОМИСС

**АЛБАДАН ХӨДӨЛМӨР БОЛОН
АЖИЛД ЗУУЧЛАХ, АВАХ ХАРИЛЦААНД
ШУДАРГА БАЙДЛЫГ ХАНГАХ ТАЛААР
СУРВАЛЖЛАХ НЬ**

СЭТГҮҮЛЧДЭД ЗОРИУЛСАН ГАРЫН АВЛАГА

ОЛОН УЛСЫН ХӨДӨЛМӨРИЙН ХЭМ ХЭМЖЭЭ хөдөлмөрийн хүрээний суурь зарчим ба эрх
эвлэлдэн нэгдэх эрх чөлөө ба хамтын хэлэлцээ хийх эрхийг бодитоор хүлээн зөвшөөрөх
АЛБАДАН ХӨДӨЛМӨРИЙН БҮХ ХЭЛБЭРИЙГ ХОРИГЛОХ ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨРИЙН ТЭВЧИШГҮЙ ХЭЛБЭРҮҮДИЙГ БҮР МӨСӨН УСТГАХ
АЖИЛ МЭРГЭЖИЛ, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ХҮРЭЭНД ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТЫГ УСТГАХ АЖИЛД ЗУУЧЛАХ, АВАХ ХАРИЛЦААНД
ШУДАРГА БАЙДЛЫГ ХАНГАХ ЕРӨНХИЙ ЗАРЧИМ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УДИРДАМЖ АЖИЛД ЗУУЧЛАХ АВАХТАЙ ХОЛБООТОЙ ТӨЛБӨР,
БУСАД ЗАРДАЛ ажиллах хүчний шилжилт хөдөлгөөн зохистой хөдөлмөр ЦАГААЧ АЖИЛЧИД АЖИЛЛАГЧИД зуучлагчид
ГЭРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖИЛЧИД ажил олгогч, ажилтны төлөөллийн байгууллага

**АЛБАДАН ХӨДӨЛМӨР БОЛОН
АЖИЛД ЗУУЧЛАХ, АВАХ
ХАРИЛЦААНД ШУДАРГА БАЙДЛЫГ
ХАНГАХ ТАЛААР СУРВАЛЖЛАХ НЬ**



СЭТГҮҮЛЧДЭД ЗОРИУЛСАН ГАРЫН АВЛАГА

© Олон Улсын Хөдөлмөрийн байгууллага 2024

Анхны хэвлэл 2020

Хоёр дахь (шинэчилсэн) хэвлэл 2024



Attribution 4.0 International (CC BY 4.0)

Энэхүү хэвлэлийг Creative Commons Attribution 4.0 Олон улсын тусгай зөвшөөрлийн хүрээнд олон нийтэд нээлттэй байршуулсан болно (<https://creativecommons.org/licenses/by/4.0/>). Тусгай зөвшөөрлийн хүрээнд уг тайланг дахин ашиглах, нийтэд түгээх, нэмж өөрчлөх, хөгжүүлэх боломжтой. Ингэхдээ ОУХБ-ыг хэвлэлийн анхны хувилбарыг эзэмшигч гэдгийг тодорхой тусгаж өгнө. Дахин ашиглах, нийтэд түгээх, нэмж өөрчлөх, хөгжүүлэх тохиолдолд ОУХБ-ын логог ашиглахыг хориглоно.

Зохиогч – Хэвлэлийг дараах байдлаар эшлэнэ: *Албадан хөдөлмөр болон ажилд зуучлах, авах харилцаанд шударга байдлыг хангах талаар сурвалжлах нь: Сэтгүүлчдэд зориулсан гарын авлага*, Улаанбаатар: Олон улсын хөдөлмөрийн товчоо, 2024. © ILO.

Орчуулга – Энэхүү хэвлэлийг орчуулсан тохиолдолд дараах тайлбарыг заавал оруулсан байх ёстой: *Энэ нь ОУХБ-ын зохиогчийн эрх бүхий бүтээлийн орчуулга юм. ОУХБ нь энэхүү орчуулгыг бэлтгэж, хянаж, батлаагүй бөгөөд ОУХБ-ын албан ёсны орчуулга биш юм. Тус хувилбарын агуулга, үнэн зөв байдлыг ОУХБ хариуцахгүй бөгөөд орчуулан гаргасан зохиогчид бүрэн хариуцна.*

Өөрчлөлт – Хэвлэлийн агуулгыг өөрчлөн гаргасан тохиолдолд дараах тайлбарыг заавал оруулна: *Энэхүү бүтээл нь ОУХБ-аас гаргасан зохиогчийн эрх бүхий бүтээлийг өөрчлөн боловсруулсан хувилбар юм. ОУХБ нь энэхүү хувилбарыг бэлтгэж, хянаж, батлаагүй бөгөөд ОУХБ-аас албан ёсоор өөрчлөн боловсруулсан хувилбар биш болно. Тус хувилбарын агуулга, үнэн зөв байдлыг ОУХБ хариуцахгүй бөгөөд өөрчлөн гаргасан зохиогчид бүрэн хариуцна.*

Гуравдагч талын материал – Энэхүү тусгай зөвшөөрөл нь бүтээлд тусгагдсан ОУХБ-ын бус зохиогчийн эрхтэй хэсэгт хамаарахгүй. Хэрэв тус хэвлэлд эшлэгдсэн гуравдагч талын зохиогчийн эрх бүхий материалыг ашиглах бол эзэмших эрх болон аливаа зөрчлийн асуудлаар зөвхөн тухайн зохиогчид хандана.

Тусгай зөвшөөрлийн дагуу үүссэн, эвийн журмаар шийдвэрлэх боломжгүй аливаа маргааныг НҮБ-ын Олон Улсын Худалдааны Эрхийн Комиссын Арбитрын журмын дагуу арбитрын шүүхэд шилжүүлнэ. Маргааныг арбитрын шүүх эцэслэн шийдэх бөгөөд талууд шийдвэрийг биелүүлэх үүрэгтэй.

Зохиогчийн эрх болон тусгай зөвшөөрөлтэй холбоотой аливаа асуудлаар ОУХБ-ын Хэвлэлийн албанд (Зохиогчийн эрх ба тусгай зөвшөөрөл) rights@ilo.org хаягаар хандана уу. ОУХБ-ын хэвлэл болон дижитал бүтээгдэхүүний талаарх мэдээллийг дараах холбоосоор авах боломжтой: www.ilo.org/publns.

ISBN: 9789220402870 (хэвлэмэл) 9789220402887 (веб pdf)

Энэхүү хэвлэлийн англи хэл дээрх хувилбар: Reporting on forced labour and fair recruitment: An ILO toolkit for Mongolian journalists, ISBN:9789220402863 (web PDF)

ОУХБ-ын мэдээллийн сан, хэвлэлд ашиглагдсан материал нь НҮБ-ын зарчимд нийцсэн бөгөөд ОУХБ-ын аливаа улс орон, нутаг дэвсгэрийн эрх зүйн байдал, эрх мэдэл, эсвэл тэдгээрийн хил хязгаарын талаарх илэрхийлсэн байр суурь, илэрхийлэл биш болно.

Хэвлэлд тусгагдсан үзэл, санаа бодол нь зөвхөн зохиогчийнх бөгөөд ОУХБ-ын үзэл, санаа бодол, эсвэл бодлого биш юм.

Байгууллага, бүтээгдэхүүн, үйл явцыг эш татах нь ОУХБ-аас албан ёсоор хүлээн зөвшөөрсөн гэсэн утгыг илэрхийлэхгүй. Мөн бусад байгууллага, бүтээгдэхүүн, үйл явцыг дурдаагүй нь хүлээн зөвшөөрөөгүйн шинж биш юм.

Монгол Улсад хэвлэв.

Гарын авлагын Монголын сэтгүүлчдэд зориулсан анхны хувилбарыг ОУХБ-ын зөвлөх сэтгүүлчид болох Жаргалсайханы Оюунцэцэг, Чарльз Аутемэн нар Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс (ХЭҮК)-той хамтран боловсруулсан. Үндэсний хууль тогтоомжийн хэсгийг шинэчилсэн хоёр дахь (шинэчилсэн) хэвлэлийг Жаргалсайханы Оюунцэцэг ХЭҮК-ын багтай хамтран боловсруулав.

Энэхүү гарын авлагын үндсэн мэдээллийг дараах эх үүсвэрээс авч, Монгол Улсын нөхцөлд нийцүүлэн боловсруулав: Toolkit for Journalists. Reporting on Forced Labour and Fair Recruitment, ISBN: 978-92-2-133006-6 (print), 978-92-2-133007-3 (web pdf), Geneva (2019) and its subsequent adapted edition, ISBN: 978-92-2-133173-5 (print), 978-92-2-133174-2 (web pdf), Sri Lanka (2019).

Энэхүү хэвлэлийг АНУ-ын Хөдөлмөрийн департаментаас IL-39460-22-75-K- дугаартай хамтын ажиллагааны гэрээний хүрээнд санхүүжүүлэв. Холбооны нөөцийн сангаас 100 хувь санхүүжиж буй олон улсын төслийн нийт төсөв 7,150,000 доллар. Энэхүү материал нь АНУ-ын Хөдөлмөрийн департаментын үзэл бодол, бодлогыг илэрхийлээгүй бөгөөд аливаа худалдааны нэршил, арилжааны бүтээгдэхүүн, байгууллагыг дурдсан нь АНУ-ын Засгийн газар тэдгээрийг хүлээн зөвшөөрснийг илтгэхгүй болно.

ТАЛАРХАЛ

Олон улсын хөдөлмөрийн байгууллага энэхүү гарын авлагыг анхлан боловсруулсан билээ. Нэгдсэн Үндэстний Байгууллагын төрөлжсөн байгууллага болох Олон улсын хөдөлмөрийн байгууллага нь 187 гишүүн орны Засгийн газар, ажил олгогч, ажилтны төлөөллийг нэгтгэн ажилладаг. Тус байгууллага 1919 онд үүсэн байгуулагдсан цагаасаа нийт эрэгтэй, эмэгтэйчүүдийн зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд чиглэсэн хөдөлмөрийн хэм хэмжээг тогтоон, бодлого, хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж байна.

Гарын авлага боловсруулах ажилд Олон улсын сэтгүүлчдийн холбоо, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Соёл иргэншлийн эвсэл зэрэг байгууллага болон дэлхийн өнцөг булан бүрээс сэтгүүлчид оролцож, хувь нэмрээ оруулсныг энд цохон тэмдэглэхэд таатай байна. Олон улсын хөдөлмөрийн байгууллага бусад холбогдох байгууллагаас хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллаж, хэрэгжүүлсэн хөтөлбөрүүдийн туршлага, сургамжид үндэслэн Чарльз Аутемэн, Кевин Берден, Кассандра Гибор Сира, Николаса Кастеллано, Лу Тессье, Жейн Коломбини, Мари Галлотти, Мелани Бельфиоре, Клары ван Панхуйс нарын баг тус гарын авлагын эх хувилбарыг боловсруулсан юм.

Улмаар өнгөрсөн 2020 онд Жаргалсайханы Оюунцэцэг, Чарльз Аутемэн нарын зөвлөх баг Чойжоогийн Алтангэрэл, Ганхуягийн Агар-Эрдэнэ, Загдаагийн Өнөржаргал нарын бүрэлдэхүүнтэй Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын ажлын хэсэгтэй хамтарч уг гарын авлагыг Монголын сэтгүүлчдэд зориулан шинэчлэн боловсруулсан бөгөөд Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Хөдөлмөрийн хүрээний суурь зарчим ба эрхийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн Барати Флюг дэмжлэг үзүүлж, санал, зөвлөгөө өгч ажилласан.

Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас АНУ-ын Хөдөлмөрийн департаментын санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Бриж II төсөл”-ийн хүрээнд энэхүү гарын авлагыг дахин шинэчилж, албадан хөдөлмөр, ажиллах хүчний шилжилт хөдөлгөөн, тэдгээртэй холбоотой харилцааг зохицуулсан хууль тогтоомжид орсон нэмэлт, өөрчлөлтийг тусгалаа. “Бриж II төсөл” нь Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Албадан хөдөлмөрийн тухай 2014 оны протокол, зөвлөмжийн дагуу олон улсын болон үндэсний түвшинд албадан хөдөлмөртэй тэмцэх чадавхыг дэмжих зорилготой юм.

Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас гарын авлагын холбогдох хэсгийг шинэчлэх ажлыг хариуцан гүйцэтгэсэн зөвлөх Жаргалсайханы Оюунцэцэг, уг ажилд дэмжлэг үзүүлж, хамтран ажилласан Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Дугарын Сүнжид, Комиссын гишүүн Жаргалсайханы Хунан, Тамгын газрын дарга Цээхээгийн Адъяахишиг, Хүний эрх хамгаалагчийн хэлтсийн дарга Загдаагийн Өнөржаргал, Хүний эрхийн сургалт, сурталчилгааны хэлтсийн дарга Хишгээгийн Цэцгээ, Хүний эрхийн боловсрол хариуцсан референт Отгонсүрэнгийн Тодбулаг, Хэвлэл мэдээлэл хариуцсан мэргэжилтэн Гончигийн Нацаг-Эрдэнэ нарт талархал илэрхийлж байна.

АГУУЛГА

ТАЛАРХАЛ	i
ТАНИЛЦУУЛГА	v
МОДУЛЬ 1. ҮЙЛ ЯВДЛЫГ ОЙЛГОХ НЬ	01
1.1. ХЭСЭГ – НИЙТЛЭГ НЭР ТОМЬЕОНЫ ЭРЭЛД	02
1.2. ХЭСЭГ – АЛБАДАН ХӨДӨЛМӨР	04
1.3. ХЭСЭГ – АЖИЛД ЗУУЧЛАХ, АВАХ ХАРИЛЦААНД ШУДАРГА БАЙДЛЫГ ХАНГАХ ЗАМААР ЗОХИСТОЙ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХ БОЛОМЖИЙГ ХАНГАХ НЬ	05
1.4. ХЭСЭГ – ЭРХ ЗҮЙН ОРЧИН	09
МОДУЛЬ 2. МЭДЭЭЛЛИЙГ ХАЙЖ ОЛОХ НЬ	17
2.1. ХЭСЭГ – АЖИЛД ЗУУЧЛАХ НЬ	18
2.2. ХЭСЭГ – МЭДЭЭЛЛИЙГ ХАЙЖ ОЛОХ НЬ	19
2.3. ХЭСЭГ – ОЛОН НИЙТИЙН ДЭМЖЛЭГ АВАХ НЬ	26
МОДУЛЬ 3. ҮЙЛ ЯВДЛЫГ БАРИМТЖУУЛАХ НЬ	29
3.1. ХЭСЭГ – БИЧГЭН БОЛОН БАРИМТАТ ЭХ СУРВАЛЖ	30
3.2. ХЭСЭГ – АЮУЛГҮЙ БАЙДАЛ	30
3.3. ХЭСЭГ – “АМАН” ЭХ СУРВАЛЖ	34
МОДУЛЬ 4. ҮЙЛ ЯВДЛЫГ ӨГҮҮЛЭХ НЬ	37
4.1. ХЭСЭГ – ЯМАР ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЭЛ СОНГОХ ВЭ?	38
4.2. ХЭСЭГ – ЦУВРАЛ БҮТЭЭЛ БЭЛТГЭХ НЬ	40
4.3. ХЭСЭГ – ТА БЭЛЭН ҮҮ?	42
МОДУЛЬ 5. БҮТЭЭЛИЙН ҮР ДҮНГ ҮЗЭХ НЬ	43
5.1. ХЭСЭГ – ҮР НӨЛӨӨ, ШАГНАЛ БОЛОН МЭРГЭШСЭН БАЙДАЛ	44
5.2. ХЭСЭГ – СҮҮЛИЙН ЗӨВЛӨМЖ	46

ТАНИЛЦУУЛГА

ЯАГААД ЭНЭХҮҮ ГАРЫН АВЛАГЫГ ХЭРЭГЛЭХ ЁСТОЙ ВЭ?

Энэхүү гарын авлагыг албадан хөдөлмөр болон ажилд зуучлах, авах харилцаанд шударга байдлыг хангах талаар сурвалжилга хийхэд тань туслах зорилгоор бүтээлээ. Гарын авлагын агуулгыг судлахад танд урьдач мэдлэг шаардлагагүй. Та өөрт боломжтой цаг, хэмнэлд тохируулан энэ товхимолыг ашиглаж болно.

Энэхүү гарын авлагын логик дарааллыг дагаж мөрдөхийг бид санал болгож байгаа боловч нөхцөл байдал, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн уялдуулж хэрэглэх нь зүйтэй юм. Хэрэв танд дарааллыг нэг бүрчлэн дагахад цаг зав бага байгаа бол хамгийн хэрэгтэй, нэн шаардлагатай хэсгээс эхлэн алхам алхмаар судалж, мэдлэгээ бататгах боломжтой юм.

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ҮҮРЭГ

“АМЬД ҮЛДЭХИЙН ТУЛД НОХОЙН ХООЛ ИДЭХЭЭС ӨӨР АРГАГҮЙ БАЙСАН”¹

– Хьюго Бачега

Мария (нэрийг өөрчилсөн болно) Сан–Паулогийн баян чинээлэг гэр бүлд гэрийн үйлчлэгчээр ажиллахаар Филиппин Улсаас Бразил Улсад ирсэн байна.

Тэрээр сургуулийн насны гурван хүү, бас нэг нялх хүүхэдтэй ээжид туслах ёстой байв. Ингээд том орон сууцыг цэвэрлэж, нохойг нь салхилуулж, хүүхдүүдийг унтах цагт оронд нь оруулж, унтуулдаг байна. Марияг ажил олгогч нь хэдэн долоо хоног амруулахгүй ажиллуулжээ. Хийх ажилдаа дарагдсан түүнд хооллох цаг бараг гардаггүй байлаа. Нэг өглөө сэрэхэд ихэд өлссөнөөс болж ходоод нь өвдөж байсан ч түүний хийх ёстой ажлууд аль хэдийнээ овоорсон байв. Хэдэн цагийн дараа түүнд багахан хоол олдов. Тэрээр айлын нохойн хоолыг бэлтгэхдээ талыг нь өөртөө авчээ.

“Надад амьд үлдэхэд үүнээс өөр ямар ч сонголт байгаагүй” хэмээн тэрээр хэлжээ. Мария ажилд зуучилсан агентлагтаа 2,000 ам.доллар (1,500 фунт) төлсөн байна. Түүний ажил олгогч нь агентлагт 6,000 ам.доллар болон Бразил Улс руу ирэх нислэгийн зардлыг төлжээ. Ажилд орох өргөдөл гаргах үед виз ажилтай эсэхээс нь хамаарна гэдгийг түүнд хэлээгүй байна. Иймд хүнд нөхцөлд байсан ч шууд гарч явж, өөр ажил хайж чадахгүй байв. Шинээр ажил хийх зөвшөөрөл авахын тулд тэр Бразил Улсаас явах ёстой байв.”

¹ Bacheга, H. Modern slavery: ‘I had to eat the dog’s food to survive’. BBC News, 2017.

Энэ мэдээ жирийн иргэний хувьд уншигчийг маш их бухимдуулж болно. Харин сэтгүүлчийн хувьд та энэ асуудлыг шийдвэрлэхэд ямар нэг зүйл хийх боломжтой байж мэднэ.

Албадан хөдөлмөр болон ажилд зуучлах, авах харилцаанд шударга байдлыг хангах зэрэг хүний эрхийн асуудлаар сурвалжилж бичих нь ердийн мэдээ бичихтэй адилгүй. Эрэн сурвалжлах, янз бүрийн эх сурвалжтай ярилцах, асуудлыг дэнслэх, нягтлах зэрэг үйл явц шаардлагатай байдаг тул цаг хугацаа ихээхэн шаардана.

Албадан хөдөлмөр болон ажилд зуучлах, авах харилцаанд шударга байдлыг хангах тухай олон мэдээ “glocal” буюу “олон улс болон орон нутгийн хосолмол” шинжтэй байдаг. Өөрөөр хэлбэл үр нөлөө нь орон нутгийн шинжтэй боловч үр дагавар нь дэлхийн хэмжээний асуудал болдог. Тухайлбал хувцасны үйлдвэрт “хашигдсан” ажиллагчид зарим уншигчдын өмсөж буй хувцсыг оёдог ч байж мэднэ.

Тиймээс орчин үеийн эдийн засгийн харилцаа хамаарал, олон улсын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн механизмыг ойлгох нь энэ сэдвээр мэдээлж, сурвалжлахад чухал ач холбогдолтой юм.

Дараа дараагийн хэсгүүдэд албадан хөдөлмөр болон ажилд зуучлах, авах харилцаанд шударга байдлыг хангах талаар алдаагүй, үр дүнтэй сурвалжлахад тань туслах зорилготой мэдээлэл, зөвлөгөөг орууллаа. Сайн сурвалжилга хийхтэй холбоотой олон жишээ болон байнга сорилт дагуулдаг сэдвээр ажиллаж, туршлагатай болсон сэтгүүлчдийн зөвлөмжийг багтаасан болно.

БИДНИЙ ТУХАЙ

Олон улсын хөдөлмөрийн байгууллага энэхүү гарын авлагыг анхлан боловсруулсан билээ. Нэгдсэн Үндэстний Байгууллагын төрөлжсөн байгууллага болох Олон улсын хөдөлмөрийн байгууллага нь 187 гишүүн орны Засгийн газар, ажил олгогч, ажилтны төлөөллийг нэгтгэн ажилладаг. Тус байгууллага 1919 онд үүсэн байгуулагдсан цагаасаа нийт эрэгтэй, эмэгтэйчүүдийн зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд чиглэсэн хөдөлмөрийн хэм хэмжээг тогтоон, бодлого, хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж байна.

Энэхүү гарын авлага нь Нэгдсэн Үндэстний Байгууллагаас дүрвэгсэд болон цагаач иргэдийн эрх, аюулгүй байдал, эрхэм чанарыг дэмжих зорилгоор зохион байгуулсан “ХАМТДАА (TOGETHER)” аян, түүнчлэн Албадан хөдөлмөрийн тухай Олон улсын хөдөлмөрийн байгууллагын протоколд нэгдэн орохыг дэмжсэн “Эрх чөлөөний төлөөх 50 (50 for Freedom)” аянд хувь нэмэр оруулахад чиглэсэн болно.

Түүнчлэн дэлхий даяар албадан хөдөлмөр, орчин цагийн боолчлол, хүн худалдаалах гэмт хэрэг, хүүхдийн хөдөлмөрийг устгах талаарх Тогтвортой хөгжлийн зорилгуудын 8.7 дахь зорилтод хүрэхээр чиглэсэн олон улсын түншлэл болох Эвсэл 8.7 (Alliance 8.7)-д цаашид хувь нэмрээ оруулахыг зорилоо.

Гарын авлагад Олон улсын сэтгүүлчдийн холбоо, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Соёл иргэншлийн эвсэл болон дэлхийн өнцөг булан бүрийн сэтгүүлчид зэрэг олон байгууллага, оролцогчид хувь нэмрээ оруулсан билээ.

Модуль 1

ҮЙЛ ЯВДЛЫГ ОЙЛГОХ НЬ



1.1. ХЭСЭГ - НИЙТЛЭГ НЭР ТОМЪЁНЫ ЭРЭЛД

Албадан хөдөлмөр болон ажилд зуучлах, авах харилцаанд шударга байдлыг хангах тухай мэдээлэхдээ зарим үг хэллэгийг хуульчлан тодорхойлсон бол заримыг нь тодорхойлоогүй байдгийг мэдэх нь чухал юм. Тодорхойлолт, тайлбарыг ойлгох нь аливаа мэдээ, сурвалжилгаас өмнө хийх ёстой бэлтгэл ажлын хэсэг болно.

Хэрэв хэрэглэж буй үг хэллэгийн утгыг бүрэн ойлгоогүй байвал таны сурвалжилга, нийтлэл алдаагүй байх, мэдээлэл болон мэдээллийн эх сурвалжууд баталгаатай байх, хэлэлцүүлэг өрнүүлэх зэрэг бүтээлийн чанар буурах болно.

Толь бичиг, нэр томъёоны тайлбар, хэвлэл мэдээллийн гарын авлагууд нь цаашид энэ чиглэлээр мэргэших, сэтгүүлзүйн бүтээлийн чанарыг сайжруулах гол эх сурвалж юм. Олон улсын хөдөлмөрийн байгууллага, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Соёл иргэншлийн эвслээс хэвлэл мэдээллийнхэнд зориулсан шилжилт хөдөлгөөний тухай нэр томъёоны тайлбар² боловсруулсан нь сэтгүүлчид болон бусад оролцогчдын хувьд гол удирдамж болдог.

1.2. ХЭСЭГ – АЛБАДАН ХӨДӨЛМӨР

Албадан хөдөлмөр олон янзаар илэрч болно. Хохирогчид ихэвчлэн маш бага цалинтай, эсвэл огт цалингүй ажилд хууртагдан орсон, өрийн барьцаанд орсон, мөн иргэний бичиг баримтаа хураалгасан зэргээс ажлаа орхиж явах боломжгүй нөхцөлд ордог. Ядуурал, бичиг үсэг үл мэдэх байдал, ялгаварлан гадуурхалт, шилжилт хөдөлгөөн зэрэг нь ажиллагчдыг албадан хөдөлмөрт илүү өртөмтгий болгодог зарим хүчин зүйлс юм.

А. АЛБАДАН ХӨДӨЛМӨР ГЭЖ ЮУ ВЭ?

Албадан хөдөлмөр гэх нэр томъёо нь аливаа нэг шийтгэл хүлээх заналхийлэл дор хувь хүний хийж гүйцэтгэж буй ажлаар илэрдэг албадлагын хөдөлмөрийн өргөн хүрээний практик ойлголтыг хамруулна. Албадан хөдөлмөр эрхэлж байгаа хүмүүс уг ажилд ажиллах эсэхээ мэдээлэлд үндэслэн чөлөөтэй шийдвэрлэж зөвшөөрөөгүй байдаг. Хүн худалдаалах гэмт хэрэг, өрийн төлөөс болгох, боолын хөдөлмөр, орчин цагийн боолчлол зэрэг нь албадан хөдөлмөрийн нөхцөл байдлыг тодорхойлоход хэвлэл мэдээллийнхний ашигладаг нэр томъёо билээ. Дэлхий даяар 27.6 сая хүн албадан хөдөлмөрт хохирч байна гэсэн судалгаа байдаг. Олон улсын хөдөлмөрийн байгууллагын мэдээлж байгаагаар албадан хөдөлмөрийн хэлбэр нь дэлхийн хаана ч, Ази, Номхон далай, Төв Ази, Европ, Африк, Араб болон Америк зэрэг бараг бүх тив, газарт илэрч байна гэжээ.

² https://www.ilo.org/wcmsp5/groups/public/---ed_protect/---protrav/---migrant/documents/publication/wcms_310235.pdf

Б. ХҮМҮҮС ХЭРХЭН УРХИНД ОРДОГ ВЭ?

Зарим ажиллагчид ялгаварлан гадуурхалтад өртдөг (жишээ нь цөөнх), эсвэл бусдаас тусгаарлагдсан байдаг (жишээ нь цагаач ажилчид) зэргээс шалтгаалж албадан хөдөлмөрт илүү их өртөх магадлалтай. Тухайлбал гэрийн үйлчилгээний ажилчид зэрэг нүднээс далд, хаалттай хаалганы цаана хөдөлмөр эрхэлж байгаа хүмүүсийн эрх нь зөрчигдөх, хүчирхийлэлд өртөх өндөр эрсдэлтэй юм.

В. АЛЬ САЛБАРТ ЯМАР ТӨРЛИЙН АЖИЛ ВЭ?

Хөдөлмөрийн зах зээл дэх албан болон албан бус салбарын алинд нь ч албадан хөдөлмөр илэрч болох бөгөөд ихэвчлэн бага цалин хөлстэй ажилд зүй бус үйлдэл, хөдөлмөрийн мөлжлөгт өртөх магадлал их байна.

Г. АЖИЛД ЗУУЧЛАХ, АВАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ПРАКТИК

Албадлага хэрэглэсэн эсэх нь ихэвчлэн илэрхий мэдэгддэггүй бөгөөд илрүүлэхэд хэцүү байдаг. Харин албадан хөдөлмөрлүүлэх үед худал амлалт өгөх зэргээр хууран мэхэлж ажилд зуучлах, авах явдал элбэг байна. Цагаач ажилчдын хувьд ажлын байрны мэдээллийн цорын ганц эх сурвалж хувийн болон албан бус зуучлагчид юм. Энэ нь тэдэнд ажлын байрны мөн чанар, хөдөлмөрийн нөхцөлийн талаар худал мэдээлэл өгөхөд амар байдаг.

Монгол Улсад Засгийн газар ажилд зуучлах, авах үйл ажиллагааг эрхлэх нь бага боловч энэ чиглэлээр зохицуулах, хяналт тавихад голлох үүргийг гүйцэтгэдэг. Засгийн газар хүлээн авагч улс оронтой энэ чиглэлээр хоёр талт гэрээ байгуулах, хөдөлмөрийн гэрээгээр ажиллуулах, үйлдвэрлэлийн дадлага хийлгэх, зуучлах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, үйл ажиллагаанд нь хяналт тавих зэрэг үүрэгтэй байна. Гэсэн хэдий ч ажил хайгч болон гадаадад цагаачлан ажиллах хүсэлтэй иргэдийн хувьд ажилд зуучлах, авах харилцаанд шударга бус хандах, эрх нь зөрчигдөх эрсдэл өндөр байна.

Д. ЯЛ ЗАВШИХ БА АШИГ ОРЛОГО

Хууль бус ажилд зуучлагчид болон ажил олгогчид асар их хууль бус ашиг олж авдаг бөгөөд тэд мөрдөн байцаалтад өртөлгүй, ял шийтгэлээс мултарч чадахуйц хэмжээнд хүчирхийлэл үйлдэх орчинг бүрдүүлэхэд гаршсан байдаг. Хохирогчид болон тэдний гэр бүл орлогын эх үүсвэрээ алдаж, үүний үр дүнд ядуурлаас гарах боломжгүй болно. Энэ нь шударга бус өрсөлдөөнийг ёс зүйтэй компаниудын хувьд бий болгож, улмаар бүхэл бүтэн салбарын нэр хүндэд халтай болдог. Тиймээс энэ асуудлыг ажилд зуучлагч, ажил олгогч, хууль тогтоогч зэрэг бүх талын оролцоотой шийдвэрлэх ёстой. Ингэвэл талууд өөрсдийн үүрэг хариуцлагад нухацтай хандаж, хуулийг дагаж мөрддөг.

Е. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨН БА АЛБАДАН ХӨДӨЛМӨРИЙН ЭРСДЭЛ

Цагаач ажилчид албадан хөдөлмөрт хамгийн өртөмтгий бүлгийн нэг юм. Өөрийн улс дотор, эсвэл гадаадад байгаагаас үл хамаарч албадан хөдөлмөрт өртөгчдийн 44 орчим хувь нь цагаач ажилчид байна. Эдгээр ажиллагчид нь эх орноо орхиж өөр улсад очоод, ялангуяа тухайн улсын хэлээр ярьж чаддаггүй тохиолдолд хөдөлмөрийн мөлжлөгт илүү өртөх болдог.

Өрийн төлөөс болгох

Өрийн төлөөс болгох нь ажиллагчдыг урхиндаа байлгахад ашигладаг албадлагын хамгийн түгээмэл хэлбэр юм. Хувийн хэвшил дэх албадан хөдөлмөрийн хохирогчдын 51 хувь нь үүнд өртдөг байна. Замын зардал зэргээ зээлэхийг зөвшөөрснөөр ажилтан, ажил олгогчдынхоо өмнө өрөнд унана. Улмаар энэ өрийг нь ашиглан хүү нь гэнэт “өссөн” буюу далд төлбөр, зардал гарсан гэх зэргээр мэхэлж булхайцдаг.

Паспорт хураах

Паспорт болон иргэний бусад бичиг баримтыг хурааж авах нь мөн л албадлагын хамгийн түгээмэл хэлбэрийн нэг бөгөөд цагаач ажилчдын чөлөөтэй зорчих эрх чөлөөг хязгаарлаж, тэднийг туслалцаа хайх боломжгүй болгон, нэг ёсондоо албадан хөдөлмөрийн дөнгөнд үлдээдэг байна. Энэ нь албадан хөдөлмөрийг илтгэх 11 үзүүлэлтийн нэг юм. Цөөнгүй оронд энэ нь тодорхой төрлийн тухайлбал ажил олгогчийнхоо гэрт нь амьдардаг гэрийн үйлчилгээний ажилчид зэрэг ажиллагчдын хувьд нийтлэг практик болсон байна.

Цалинг барьцаалах

Орон сууц, багаж хэрэгслийн зардлыг нөхөхийн тулд цалинг барьцаалдаг. Ингэснээр ажилтан нь ажил олгогчоосоо хоол хүнс, орон сууцны хувьд хараат болох нөхцөл бүрдэнэ³.

Ё. АЛБАДАН ХӨДӨЛМӨРИЙГ УСТГАХ НЬ

Албадан хөдөлмөр нь хүний эрхийн ноцтой зөрчил бөгөөд олон улсын эрх зүйд эрүүгийн гэмт хэрэгт тооцдог. Гэм буруугийн хор уршгийг харгалзаж зохих ял шийтгэх, буруутай этгээдийг дахин ийм үйлдэл гаргахаас сэргийлэх ёстой. Ихэнх улс оронд албадан хөдөлмөр, хүн худалдаалах гэмт хэрэг, боолчлол зэргийг үндэсний хууль тогтоомжоороо хориглодог хэдий ч гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ял шийтгэл хүлээлгэсэн тохиолдол цөөхөн байна.

Ж. ЗОХИЦУУЛАХЫН АЧ ХОЛБОГДОЛ

Хөдөлмөрийн зах зээл уналтад орж, ажиллагчид хамгаалалтгүй үлдэх тохиолдолд тэдний хамгийн эмзэг хэсэг нь хөдөлмөрийн мөлжлөгийн эрсдэлд өртдөг. Зохистой хөдөлмөрийг дэмжих хүрээнд Олон улсын хөдөлмөрийн байгууллага өнгөрсөн хугацаанд албадан хөдөлмөрийг зогсоход чиглэсэн олон улсын хөдөлмөрийн хэд хэдэн хэм хэмжээг боловсруулан гаргав. Зарим нь албадан хөдөлмөрийг ерөнхийд нь хөндөхийн зэрэгцээ мөн хүүхдийн хөдөлмөр, гэрийн үйлчилгээний ажил зэрэг тодорхой асуудалд төвлөрч байна.

Албадан хөдөлмөртэй тэмцэхийн тулд олон улсын болон үндэсний түвшинд хөдөлмөрийн зах зээлийг үр дүнтэй зохицуулах, мөн Хөдөлмөрийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохих ёсоор хангуулах шаардлагатай юм.

³ Өр, цалингаар нь барьцаалах, паспорт, бичиг баримтыг хураах зэрэг нь албадан хөдөлмөрлүүлж байж болзошгүйг илтгэх үзүүлэлтүүд юм. Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас албадан хөдөлмөрийн 11 шалгуур үзүүлэлтийг гаргасан байна. https://www.ilo.org/beijing/what-we-do/publications/WCMS_537158/lang-en/index.htm

1.3. ХЭСЭГ-АЖИЛД ЗУУЧЛАХ, АВАХ ХАРИЛЦААНД ШУДАРГА БАЙДЛЫГ ХАНГАХ ЗАМААР ЗОХИСТОЙ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХ БОЛОМЖИЙГ ХАНГАХ НЬ

Өнөөгийн даяаршсан эдийн засагт олон сая хүн амьдарч буй орон нутаг болон улс орноосоо гадуур ажлын байр хайх болсон ба олон улсын нийлүүлэлтийн сүлжээнд ажиллагчдыг ажилд зуучлах, ажилд авах явдал түгээмэл болжээ. Шилжилт хөдөлгөөний асуудал улам бүр л хөдөлмөрийн агуулгатай болж байна. Нэмж тэмдэглэхэд олон сая ажиллагч өөрийн улс орон дотроо зохистой хөдөлмөр эрхлэхээр шилжин суурьшиж байна. Ажилд зуучлах, авах харилцаанд шударга байдлыг хангах нь бүгдэд зохистой хөдөлмөр эрхлэх боломжийг олгох гол нөхцөл юм.

А. АЖИЛД ЗУУЧЛАХ, АВАХ ХАРИЛЦААНД ШУДАРГА БАЙДЛЫГ ХАНГАХ ГЭДГИЙГ ХЭРХЭН ОЙЛГОХ ВЭ?

Ажилд зуучлах, авах харилцаанд шударга байдлыг хангах асуудал нь хэдийгээр олон улсын эрх зүйгээр тодорхойлогдоогүй боловч олон улсын хэлэлцүүлгийн үндсэн сэдэв байж, Олон улсын хөдөлмөрийн байгууллагын үйл ажиллагааны гол чиглэл болсоор ирсэн ойлголт юм. “Ажилд зуучлах, авах харилцаанд шударга байдлыг хангах санаачилга” нь Олон улсын хөдөлмөрийн байгууллагын дэлхийн хэмжээнд өрнүүлсэн үйл ажиллагаа бөгөөд шударга, хүний эрхийг дээдлэсэн практик туршлагыг улс орнуудад нэвтрүүлэх зорилготой. Энэ нь дараах дөрвөн үндсэн чиг хандлагад суурилдаг. Үүнд:

1. Олон улс болон үндэсний хэмжээнд ажилд зуучлалын талаар дэлхий дахины мэдлэгийг нэмэгдүүлэх
2. Хууль тогтоомж, бодлогыг боловсронгуй болгох, тэдгээрийн хэрэгжилтийг сайжруулах
3. Бизнесийн шударга үйл ажиллагааг дэмжих
4. Ажиллагчдыг эрх мэдэлжүүлэх, хамгаалах.

Ажилд зуучлах, авах харилцаанд шударга байдлыг хангах тухай ойлголт, тодорхойлолтыг Олон улсын хөдөлмөрийн байгууллагын “Ажилд зуучлах, авах харилцаанд шударга байдлыг хангах ерөнхий зарчим, үйл ажиллагааны удирдамж”⁴-д тусгасан бөгөөд үүнд ажилд зуучлах, авах үйл явцтай холбоотой хэд хэдэн асуудлыг тусгажээ.

Ажлын байрны талаарх мэдээлэл

Ажилд зуучлах, авах харилцаанд шударга байдлыг хангах нь ажилд зуучлах, авах ажиллагааны эхний үе шатанд ажлын сул орон тоо байгаа талаарх мэдээллийг түгээх үеэс эхэлнэ. Энэ үед сонины төрөлжсөн буланд хуурамч амлалт нийтлэх зэрэг хууран мэхлэх гэх мэт шударга бус үйлдэл гарч болно. Ийм худал хуурмаг явдлыг няцаахын тулд Засгийн газар хэвлэлийн мэдээ гаргах эсвэл сурталчилгаа явуулах боломжтой.

Үүний нэг жишээ бол Солонгос, Япон, Америк, Унгар, Польш, Чех болон бусад улс оронд хөдөлмөр эрхлэхэд зуучлах нэрээр иргэдийг төөрөгдүүлэх,

⁴ Олон улсын хөдөлмөрийн байгууллага: “Ажилд зуучлах, авах харилцаанд шударга байдлыг хангах ерөнхий зарчим, үйл ажиллагааны удирдамж-Ажилд зуучлах, авахтай холбоотой төлбөр, бусад зардал”, 2020.

хуурч мэхлэх, мөнгө авах залилангийн шинжтэй үйлдлүүд гарч байгаатай холбогдуулан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас гаргасан сэрэмжлүүлэг юм. Өдөр тутмын мэдээллийн сайтад нийтлэгдсэн энэ мэдээлэлд Бүгд Найрамдах Солонгос Улсад ажиллах хүч илгээх ажлыг Монгол Улсын талаас Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, Солонгос Улсын талаас Аж үйлдвэрийн хүний нөөцийн хэрэг эрхлэх газар хариуцан зохион байгуулдаг бөгөөд хувь хүн, аж ахуйн нэгж, байгууллага хийдэггүй болохыг сэрэмжлүүлжээ. News.mn сайтын 2019 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр нийтлэгдсэн мэдээллийг харуулав⁵.

Сэрэмжлүүлэг: Гадаадад зуучлах нэрээр иргэдийг залилж байна



Сүүлийн үед гадаад улс орнууд тухайлбал Солонгос, Япон, Америк, Унгар, Польш, Чех зэрэг улс оронд хөдөлмөр эрхлэхэд зуучлах нэрээр иргэдийг төөрөгдүүлэх, хуурч мэхлэх, мөнгө авах залилангийн шинжтэй үйлдлүүд гарч байгаа учраас дараах сэрэмжлүүлэг мэдээллийг

хүргэж байна. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газраас өнөөдрийн байдлаар Солонгос болон Япон Улсад албан ёсоор иргэдийг хөдөлмөр эрхлэхэд зуучилж байна.

Ингэхдээ Бүгд Найрамдах Солонгос Улсад ажиллах хүч илгээх ажлыг Монгол Улсын талаас Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, Бүгд Найрамдах Солонгос Улсын талаас тус улсын Аж үйлдвэрийн хүний нөөцийн хэрэг эрхлэх газар хариуцан зохион байгуулдаг бөгөөд хувь хүн, аж ахуйн нэгж байгууллага хийдэггүй гэдгийг хариуцлагатайгаар мэдэгдэж байна.



2018 он. Бүгд Найрамдах Солонгос Улсад хөдөлмөрийн гэрээгээр ажиллах хүсэлтэй иргэдийн хэлний түвшин тогтоох шалгалтын бүртгэл

Япон Улсын хувьд 2017 онд байгуулсан “Ур чадвартай, техникийн дадлагажигч илгээх асуудлаарх санамж бичиг”, 2019 онд байгуулсан “Ур чадвартай ажиллах хүчний тогтолцооны зохистой ажиллагааны үндсэн хүрээг хэрэгжүүлэх хамтын ажиллагааны санамж бичиг”-ийг байгуулсан. Санамж бичгүүдийн хүрээнд ур чадвартай ажилтан

(үндсэн ажилтан) болон ур чадварын дадлагажигч илгээх хоёр тогтолцоо зэрэг хэрэгжиж байна.

Ур чадварын дадлагажигч илгээх үйл ажиллагааг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас олгосон тусгай зөвшөөрөлтэй байгууллагаар дамжуулан зохион байгуулдаг бөгөөд тусгай зөвшөөрөл бүхий зуучлагч байгууллага

⁵ News.mn, Сэрэмжлүүлэг: Гадаадад зуучлах нэрээр иргэдийг залилж байна, 2019.11.29.

иргэнийг Япон Улсад хүлээж авах компанийн ярилцлагад оруулж, болзол хангаж чадвал эрүүл мэндийн үзлэгт хамруулж тэнцсэн тохиолдолд Япон Улсын талаас оршин суух зөвшөөрлийг тухайн компани авч ирүүлнэ. Үүний дараа Япон Улсын Элчин сайдын яамнаас виз хүснэ. Энэ олон шатны ажил зуучлагч байгууллагаас бүрэн хамаардаг. Тиймээс иргэдэд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас олгосон зуучлах зөвшөөрлийн гэрчилгээг үзүүлж, манай хэлний сургалтад хамрагдаж, зуучлалын хураамж, барьцаа төлбөр төлчихвөл шууд явуулна хэмээн амлах, сурталчлах нь бодит байдалтай нийцэхгүй байгаа юм.

Ур чадвартай ажилтан илгээх үйл ажиллагааг Япон Улстай байгуулсан Санамж бичгийн дагуу зөвхөн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар хариуцан гүйцэтгэх тул энэ үйл ажиллагаанд иргэн, Япон хэлний сургалтын төвүүд, яамнаас ур чадварын дадлагажигч илгээх тусгай зөвшөөрөл авсан газрууд болон бусад байгууллагууд оролцохгүй болохыг онцгой анхааруулж байна.

Сүүлийн үед иргэн, байгууллага хэлний сургалтын үйл ажиллагаа эрхэлдэг газрууд Япон Улсад үндсэн ажилтнаар зуучилна гэх зар мэдээллийг олон нийтийн сүлжээ, цахим хэрэгслээр өргөн хүрээтэй зарлаж, үүндээ орон нутагт төрийн байгууллагуудыг татан оролцуулах байдал гарч болзошгүй байгаа тул Та бүхэнд энэ мэдээллийг хүргэн сэрэмжлүүлж байгаа юм. Мөн тус яамнаас Америк, Чех, Унгар, Польш болон бусад оронд Монгол Улсын иргэдийг хөдөлмөр эрхлэхэд зуучлах зөвшөөрөл авсан байгууллага байхгүй болохыг онцолжээ.

Хэрэв зуучлалын үйл ажиллагаа, зуучлалын хураамж, барьцаа төлбөртэй холбоотой санал, гомдол үүсвэл Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, цагдаа, хууль хяналтын байгууллагад яаралтай хандахыг зөвлөж байна.

Эх сурвалж: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

Шууд ажилд авах уу, эсвэл зуучлагчаар дамжуулах уу?

Ажилд зуучлах, авах үйл явц нь нарийн нийлмэл бөгөөд хувийн хэвшил болон төрийн байгууллагуудын оролцоотойгоор хэрэгждэг байж болно. Ажил олгогч, ажилтан хоёрын дунд зуучлагч этгээдийн тоо нэмэгдэхийн хэрээр зүй бус явдлын эрсдэл ихэсдэг. Ингэснээр ажиллагчдын өмнө ажилд зуучлах, авахтай холбоотой төлбөр, бусад зардлыг шууд ба шууд бусаар төлөх нийтлэг бэрхшээл тулгардаг байна.

Олон улсын хөдөлмөрийн байгууллагын “Ажилд зуучлах, авах харилцаанд шударга байдлыг хангах ерөнхий зарчим, үйл ажиллагааны удирдамж”-д ажилд зуучилсны төлбөр, бусад зардлыг ажилтан төлөх ёсгүй гэж заасан байдаг ч олон улс оронд ажилд зуучилсны төлбөр хураамжийг ажиллагчид хуулийн дагуу хэсэгчлэн эсвэл бүрэн хэмжээгээр төлөх явдал хэвээр байна. Түүнчлэн ажиллагчид төлж барагдуулдаг бүх зардлын тооцоогоо мэдэх нь чухал юм. Үүнд ажилтныг ажил олгогчтой холбох үйлчилгээ үзүүлсний төлөө зуучлалын агентлагийн нэхэмжилдэг “зуучлалын төлбөр хураамж”-аас гадна иргэний болон аяллын бичиг баримт, эрүүл мэндийн үзлэг, явахын өмнөх сургалт зэрэг зардал орж болно.

Тохирох ажлын байранд зуучлах

Ажилд зуучлах ажиллагаа нь ажиллагчдад мэргэшил, ур чадвар, хүсэл эрмэлзлэлд нь тохирсон ажлын байрыг санал болгосон үр ашигтай үйлчилгээ байх ёстой юм.

Б. АЖИЛД ЗУУЧИЛСНЫ ТӨЛБӨР, ХОЛБОГДОХ ЗАРДЛЫГ АЖИЛЛАГЧДААР ТӨЛҮҮЛЭХИЙГ ЗОГСООХ НЬ

Ажилд зуучлах, авах үйл явцад өндөр төлбөртэй хөндлөнгийн зуучлагчид оролцож, цалин хөлс багатай ажилд шилжин ирэгчдэд дарамт учруулдаг. Олон улсын хөдөлмөрийн байгууллага, Дэлхийн банкны судалгаа⁶-наас харахад бага орлоготой, ур чадвар, боловсрол хамгийн бага хүмүүс орлоготойгоо харьцуулахад хамгийн өндөр зардлыг төлдөг байна. Олон улсын хөдөлмөрийн байгууллагын “Ажилд зуучлах, авах харилцаанд шударга байдлыг хангах ерөнхий зарчим, үйл ажиллагааны удирдамж” нь ажилд зуучлах, авахтай холбоотой төлбөр, бусад зардлыг ажилтан бус ажил олгогч хариуцах ёстойг тодорхой шаарддаг.

В. ЭНЭ ҮЙЛ ЯВДАЛД ӨӨР ХЭН ОРОЛЦООТой ВЭ?

Ажилд зуучлах, авах харилцаанд шударга байдлыг дэмжихэд олон талууд оролцдог. Ажилд зуучлах, авах харилцаанд шударга байдлыг хангахад ахиц дэвшил гаргах эцсийн хариуцлагыг Засгийн газар хүлээж, олон улсын хэм хэмжээнд нийцсэн хууль тогтоомж, бодлогыг баталж мөрдүүлэх ёстой билээ. Ажилд зуучлагчид, төрийн хөдөлмөр эрхлэлтийн албад, төр болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагуудын ажил олгогчид мөн үйлдвэрчний эвлэл, иргэний нийгэм бүгд ажилд зуучлах, авах харилцаанд шударга байдлыг дэмжихэд чухал үүрэг гүйцэтгэнэ. Эцэст нь хэлэхэд хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь ажиллагчдыг мэдээллээр хангах, алдаа дутагдлыг нийтэд ил болгох үүрэг гүйцэтгэж чадна.

Г. ЁС ЗҮЙТЭЙ АЖИЛД ЗУУЧЛАГЧИД

Зарим хувийн зуучлагч компани/агентлагууд нь “ёс зүйтэй ажилд зуучлагч” байх сонголт хийсэн байдаг. Тэдний зүгээс ажил олгогч болон ажилтанд санал болгож буй нөхцөл, болзол нь нээлттэй байж, ажилд зуучлах, авах харилцаанд шударга байдлыг хангах удирдамжийг удирдлага болгон ажилладаг. Ажилд зуучлах, авах харилцаанд эрх зүй, ёс суртахууны зарчмыг удирдлага болгох явдлыг харуулахад тэдний туршлага чухал ач холбогдолтой юм.

⁶ The World Bank. *KNOMAD - ILO Migration Costs Surveys*, 2017.

1.4. ХЭСЭГ - ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Албадан хөдөлмөр болон ажилд зуучлах, авах харилцаанд шударга байдлыг хангах асуудлыг олон улсын болон үндэсний эрх зүйн хэм хэмжээний аль алианаар нь зохицуулсан байдаг. Олон улсын хэмжээнд мөрдөгдөх хэд хэдэн хэм хэмжээг баталжээ. Конвенц, протоколд нэгдэн орсон улс орнууд заавал дагаж мөрдөх үүрэгтэй бол харин зөвлөмжийг заавал биелүүлэх шинжгүй боловч үндэсний тогтолцоог бэхжүүлэх удирдамж болдог. Хөдөлмөрийн хүрээний таван суурь зарчим, эрхийн нэг нь албадан хөдөлмөрийн бүх хэлбэрийг устгах явдал юм. Иймээс Олон улсын хөдөлмөрийн байгууллагын бүх гишүүн улс албадан хөдөлмөртэй холбоотой хэм хэмжээнд нэгдэн орсон эсэхээс үл хамаарч тэдгээрийг хүндэтгэж, дагаж мөрдөн дэмжих ёстой.

А. ОЛОН УЛСЫН ХӨДӨЛМӨРИЙН ХЭМ ХЭМЖЭЭ

Эдүгээ Олон улсын хөдөлмөрийн бага хурлаас 191 конвенц, 6 протокол, 208 зөвлөмж баталжээ. Эдгээрийн арав нь “суурь конвенц”, дөрөв нь “засаглалын конвенц”, бусад нь “техникийн конвенц”-д хамаардаг байна⁷.

Хөдөлмөрийн хүрээний суурь зарчим ба эрхийг тогтоосон суурь арван конвенцод дараах конвенцууд хамаардаг байна. Үүнд:

- Эвлэлдэн нэгдэх эрх чөлөө болон байгууллага байгуулах эрхийг хамгаалах тухай 1948 оны Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 87 дугаар конвенц
- Зохион байгуулах, хамтын хэлэлцээ хийх эрхийн тухай Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 1949 оны 98 дугаар конвенц
- Албадан хөдөлмөрийн тухай Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 1930 оны 29 дүгээр конвенц (болон түүний нэмэлт болох 2014 оны протокол)
- Албадан хөдөлмөрийг устгах тухай Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 1957 оны 105 дугаар конвенц
- Хөдөлмөрийн насны доод хязгаарын тухай Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 1973 оны 138 дугаар конвенц
- Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн тухай Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 1999 оны 182 дугаар конвенц
- Тэгш шан хөлс олгох тухай Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 1951 оны 100 дугаар конвенц
- Алагчлахгүй байх (ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт) тухай Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 1958 оны 111 дүгээр конвенц
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 1981 оны 155 дугаар конвенц
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийг дэмжих тогтолцооны тухай Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 2006 оны 187 дугаар конвенц

⁷ Олон улсын хөдөлмөрийн байгууллага. [Олон улсын хөдөлмөрийн хэм хэмжээний талаарх танилцуулга](#), 2019.

Олон улсын хөдөлмөрийн байгууллагын холбогдох хэм хэмжээ батлагдан гарсан он тооллыг дор харуулав⁸.

1930

1949

1957

1958

1975

1997

1998

1999

2011

2014

1930

АЛБАДАН ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ ОЛОН УЛСЫН ХӨДӨЛМӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН 29 ДҮГЭЭР КОНВЕНЦ⁹

Энэхүү конвенцод нэгдэн орсон улс орнууд албадан болон заавал хийлгэх хөдөлмөрийн бүх хэлбэрийг устгах үүрэг хүлээдэг (1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг). Энэ конвенц нь албадан хөдөлмөрийн талаар хэм хэмжээ тогтоосон анхны конвенц бөгөөд “албадан болон заавал хийлгэх хөдөлмөр” түүнд үл хамаарах таван хэлбэрийг тус тус тодорхойлжээ. Түүнчлэн уг конвенцод нэгдэн орсон улс орнууд албадан хөдөлмөрлүүлсэн аливаа тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэх, түүнд нь “тохирох ял шийтгэл ногдуулж, хэрэгжилтийг нь чанд сахиулдаг байх”-ыг шаарддаг болно (25 дугаар зүйл).

1949

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХ ЗОРИЛГООР ШИЛЖИН СУУРЬШИХ ТУХАЙ (ХЯНАН ӨӨРЧИЛСЭН) ОЛОН УЛСЫН ХӨДӨЛМӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН 97 ДУГААР КОНВЕНЦ

Энэхүү конвенц нь түүнд нэгдэн орсон улс орнууд цагаач ажилчдад туслалцаа үзүүлж, мэдээллээр хангах үйлчилгээ бий болгох, ажиллуулах, гадагш чиглэсэн болон гаднаас орж ирэх шилжих хөдөлгөөнтэй холбоотой төөрөгдүүлсэн худал ташаа мэдээллийн эсрэг арга хэмжээ авах замаар хөдөлмөр эрхлэх зорилготой олон улсын шилжилт хөдөлгөөнийг хөнгөвчлөхийг шаарддаг. Мөн конвенцод цагаач ажилчдад эмнэлгийн зохистой тусламж үйлчилгээ үзүүлэх, хөдөлмөрийн хөлс, хадгаламжаа шилжүүлэх боломжоор хангах заалтууд тусгагджээ. Түүнчлэн улс орнууд хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл, эвлэлдэн нэгдэх эрх чөлөө, нийгмийн хамгааллын зэрэг олон асуудлаар өөрсдийн харьяат иргэдэд үзүүлдгээс дутуугүй таатай нөхцөлийг цагаач ажилчдад олгож, эрх тэгш хандах ёстой.

1957

АЛБАДАН ХӨДӨЛМӨРИЙГ УСТГАХ ТУХАЙ ОЛОН УЛСЫН ХӨДӨЛМӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН 105 ДУГААР КОНВЕНЦ

Энэхүү конвенцод төрийн эрх мэдэлтнүүдийн зүгээс албадан хөдөлмөр хийлгэхийг хориглох таван тодорхой тохиолдлыг шууд зааж өгчээ. Тухайлбал улс төрийн үзэл бодлоо илэрхийлснийг цээрлүүлэх, эдийн засгийн хөгжлийн зорилгоор, ажил хаялтад оролцсоны төлөө эсвэл арьс өнгө болон бусад үндэслэлээр ялгаварлан гадуурхах арга хэрэгсэл болгох, хөдөлмөрийн сахилгыг сахиулах зорилгоор албадан хөдөлмөрлүүлэхийг хориглодог байна.

⁸ Эдгээр хэм хэмжээг бүрэн эхээр нь Олон улсын хөдөлмөрийн байгууллагын цахим сайтаас үзнэ үү. www.ilo.org/normes

⁹ Монгол Улс энэ конвенцод 2005 онд нэгдэн орсон. Албадан хөдөлмөрийн тухай 29 дүгээр конвенцод нэгдэн орсныг соёрхон батлах тухай Монгол Улсын хууль, <https://legalinfo.mn/mn/detail/10259>

¹⁰ Монгол Улс энэ конвенцод 2005 онд нэгдэн орсон. Албадан хөдөлмөрийг устгах тухай 105 дугаар конвенцод нэгдэн орсныг соёрхон батлах тухай Монгол Улсын хууль, <https://legalinfo.mn/mn/detail/10260>

1958

АЛАГЧЛАХГҮЙ БАЙХ (АЖИЛ МЭРГЭЖИЛ, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ) ТУХАЙ ОЛОН УЛСЫН ХӨДӨЛМӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН 111 ДҮГЭЭР КОНВЕНЦ¹¹

Энэхүү конвенцыг дагаж мөрдөж байгаа гишүүн орон бүр ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлттэй холбогдсон аливаа ялгаварлан гадуурхалтыг бүр мөсөн устгах зорилгоор ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлтийн салбарт тэгш боломж, хандлагыг дэмжихэд чиглэсэн үндэсний бодлогыг тухайн улсын нөхцөл байдад, дадалд тохирсон аргаар тодорхойлж хэрэгжүүлэх (2 дугаар зүйл) үүрэг хүлээнэ. Мөн конвенцоор улс орнууд арьс өнгө, хүйс, шашин шүтлэг, улс төрийн үзэл бодол, үндэсний болон нийгмийн гарлаар хөдөлмөр эрхлэлтэд ялгаварлахыг хориглосон хууль тогтоомж баталж, ижил тэгш боломжийг хангаагүй хууль тогтоомжийг халахыг шаарддаг болно.

1975

ЦАГААЧ АЖИЛЧДЫН ТУХАЙ (НЭМЭЛТ ЗААЛТУУД) ОЛОН УЛСЫН ХӨДӨЛМӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН 143 ДУГААР КОНВЕНЦ

Тус конвенцод хууль бусаар, зөвшөөрөлгүй нууцаар шилжин суурьших явдалтай тэмцэх арга хэмжээг тусгахын зэрэгцээ улс орнууд нийт цагаач ажилчдын хүний суурь эрхийг хүндэтгэн хэрэгжүүлэх үүрэгтэй гэж заажээ. Түүнчлэн Хөдөлмөр эрхлэх зорилгоор шилжин суурьших тухай Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 97 дугаар конвенцын хууль ёсоор оршин суугаа цагаач ажилчид болон дотоодын ажиллагчдад эрх тэгш хандах заалтын хамрах хүрээг өргөжүүлсэн байна. Тиймээс тус конвенцод нэгдсэн орсон улс орнууд нутаг дэвсгэртээ хууль ёсоор оршин суугаа цагаач ажилчид, тэдгээрийн гэр бүлийн гишүүдэд хөдөлмөр эрхлэлт, ажил мэргэжил, нийгмийн хамгаалал, үйлдвэрчний эвлэл, соёлын эрх, хувь хүний болон хамтын эрх чөлөөний хүрээнд тэгш боломж олгож, адил тэгш хандах ёстой. Мөн конвенцоор улс орнууд нь нутаг дэвсгэртээ хууль ёсоор оршин сууж буй цагаач ажилчдын гэр бүлийг нэгтгэхэд дэмжлэг үзүүлэхийг уриалдаг байна.

1997

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ХУВИЙН БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ ОЛОН УЛСЫН ХӨДӨЛМӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН 181 ДҮГЭЭР КОНВЕНЦ¹²

Энэхүү конвенцоор “сайн ажиллагаатай хөдөлмөрийн зах зээлд хөдөлмөр эрхлэлтийн хувийн байгууллагуудын гүйцэтгэж болох үүргийг” хүлээн зөвшөөрсөн байна. Конвенцын зорилго нь хөдөлмөр эрхлэлтийн хувийн байгууллагад ажиллах боломж олгохын зэрэгцээ тэдгээрийн үйлчилгээг авч байгаа ажилчдыг хамгаалахад (2 дугаар зүйлийн 3 дахь хэсэг) чиглэсэн байна. Конвенцын 7 дугаар зүйлд зааснаар хөдөлмөр эрхлэлтийн хувийн байгууллага нь ажилчдаас шууд болон шууд бусаар бүрэн болон хэсэгчилсэн ямар ч хэмжээгээр төлбөр хураамж, бусад зардал авах ёсгүй.

1998

ХӨДӨЛМӨРИЙН ХҮРЭЭНИЙ СУУРЬ ЗАРЧИМ БА ЭРХИЙН ТУХАЙ ТУНХАГЛАЛ

Олон улсын хөдөлмөрийн байгууллагын бүх гишүүн улс холбогдох конвенцод нь нэгдэн орсон эсэхээс үл хамаарч энэхүү тунхаглалд тодорхойлсон хөдөлмөрийн хүрээний таван суурь зарчим ба эрхийг хүндэтгэх, дэмжих, хэрэгжүүлэх ёстой.

¹¹ Монгол Улс энэ конвенцод 1969 онд нэгдэн орсон, <https://legalinfo.mn/mn/detail/1185>

¹² Монгол Улс энэ конвенцод 2015 онд нэгдэн орсон. Хөдөлмөр эрхлэлтийн хувийн байгууллагын тухай Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 181 дүгээр конвенцод нэгдэн орох тухай Монгол Улсын хууль, <https://legalinfo.mn/mn/detail/10898>

Эдгээр суурь таван зарчимд эвлэлдэн нэгдэх эрх чөлөө, хамтын хэлэлцээ хийх эрх, албадан хөдөлмөр, хүүхдийн хөдөлмөр болон ялгаварлан гадуурхалтыг устгах, түүнчлэн эрүүл, аюулгүй ажиллах орчин хамаарна.

1999

ХҮҮХДИЙН ХӨДӨЛМӨРИЙН ТЭВЧИШГҮЙ ХЭЛБЭРИЙН ТУХАЙ ОЛОН УЛСЫН ХӨДӨЛМӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН 182 ДУГААР КОНВЕНЦ¹³

Энэхүү конвенцоор хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг хориглож, устгахыг шаарддаг. Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрт боолчлолын бүх хэлбэр, түүний дотор хүүхдийг худалдах, дамжуулан худалдах, өрийн төлөөс болгож албадан хөдөлмөрлүүлэх, түүнчлэн хүүхдийг дайн, зэвсэгт мөргөлдөөнд ашиглах болон бусад хэлбэрээр албадан хөдөлмөрлүүлэх явдал багтдаг. Мөн хүүхдийг бэлгийн мөлжлөгт өртүүлэх, хууль бус үйл ажиллагаанд татан оролцуулах, хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, ёс суртахуунд хор хөнөөл учруулах ажил эрхлүүлэх ч орно.

2011

ГЭРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖИЛЧДЫН ТУХАЙ ОЛОН УЛСЫН ХӨДӨЛМӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН 189 ДҮГЭЭР КОНВЕНЦ

Энэхүү конвенц нь гэрийн үйлчилгээний ажилчдын зохистой хөдөлмөрийг хангахад анхаарсан байна. Тус конвенцын 8 болон 15 дугаар зүйлд гэрийн үйлчилгээний ажилчдыг ажилд авах, тэр дундаа хувийн хөдөлмөр зуучлалын албадын гүйцэтгэх үүрэг, төлбөр хураамж, эх орондоо буцах талаар зохицуулжээ. Мөн конвенцын 9 дүгээр зүйлд зааснаар гэрийн үйлчилгээний ажилчид нь дараах эрхтэй байна. Үүнд:

- а) одоогийн болон ирээдүйн ажил олгогчтойгоо гэрт нь байрлах эсэх асуудлыг чөлөөтэй зөвшилцөж шийдвэрлэх.
- б) айлын гэрт байрлаж ажилладаг бол ээлжийн, долоо хоногийн болон өдрийн амралтын цагаар тухайн айлд, эсвэл тухайн айлын гишүүдтэй хамт байх үүрэг хүлээхгүй
- в) аяллын болон биеийн байцаалтын баримт бичгүүдээ өөртөө хадгалах.

2014

АЛБАДАН ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ (НЭМЭЛТ АРГА ХЭМЖЭЭ) ОЛОН УЛСЫН ХӨДӨЛМӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН 203 ДУГААР ЗӨВЛӨМЖ

Албадан хөдөлмөрийн тухай Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 29 дүгээр конвенц болон түүний протоколын нэмэлт болгож тус 203 дугаар зөвлөмжид албадан хөдөлмөрийн эсрэг хууль

¹³ Монгол Улс энэ конвенцод 2001 онд нэгдэн орсон, <https://legalinfo.mn/mn/detail/1275>

2014

АЛБАДАН ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ ОЛОН УЛСЫН ХӨДӨЛМӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН 29 ДҮГЭЭР КОНВЕНЦЫН ПРОТОКОЛ

тогтоомж, бодлогыг боловсронгуй болгож, албадан хөдөлмөрөөс урьдчилан сэргийлэх, хохирогчийг хамгаалах, тэднийг зөрчигдсэн эрхээ сэргээлгэх боломжоор хангах, хууль сахиулах болон олон улсын хэмжээнд хамтран ажиллах чиглэлд авах арга хэмжээний талаарх (заавал биелэх шинжгүй) практик удирдамжийг тусгасан байна. Эдгээр нь протоколын заалтуудад үндэслэсэн тул хоёр баримт бичгийг хамт хэрэглэх нь зүйтэй.

Энэхүү протокол нь албадан хөдөлмөрөөс урьдчилан сэргийлэх, хохирогчдыг хамгаалах, зөрчигдсэн эрхээ сэргээлгэх, түүний дотор нөхөн төлбөр авах боломжоор хангах талаар үр дүнтэй арга хэмжээ авахыг гишүүн улс орнуудаас шаарддаг заавал биелэх шинжтэй баримт бичиг юм. Тус протокол нь Албадан хөдөлмөрийн тухай Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 29 дүгээр конвенцын нэмэлт учраас гишүүн улс орнууд эхлээд конвенцод нэгдэн орсны дараа энэ протоколд нэгдэх боломжтой болно.

Б. УЛС ОРНУУДЫН ЗАРИМ САЙН ЖИШЭЭ¹⁴

Армян Улс

2011 оны Эрүүгийн хуульд (нэмэлт, өөрчлөлт) гэмт этгээдээс эд хөрөнгийг хураахыг зөвшөөрсөн. Түүнчлэн хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдыг нэн тэргүүнд анхаарах бүлгийн жагсаалтад оруулсан байна.

Нигери Улс

Нигери Улсын 2015 оны Хүн худалдаалахыг хориглох тухай хуулийг хэрэгжүүлэх актын 62 дахь хэсэгт “үндэслэл бүхий нөхцөлд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг уг гэмт хэрэгтэй холбоотой, тухайлбал хүчин төгөлдөр аяллын баримт бичгээ биедээ байлгаагүй, хуурамч аяллын болон бусад бичиг баримт хэрэглэсэн зэрэг зөрчил гаргасны төлөө цагдан хорьж, ял шийтгэхгүй” гэж заажээ.

Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс

Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсын 2015 оны Орчин цагийн боолчлолын тухай хуулиар албадан болон заавал хийлгэх хөдөлмөр, хүний наймаа зэргийг гэмт хэрэгт тооцжээ.

Америкийн Нэгдсэн Улс

Америкийн Нэгдсэн Улсын Засгийн газар 2012 оны 13627 тоот Гүйцэтгэх захирамждаа албадан хөдөлмөр, хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд магадлан шинжилгээ чухал болохыг онцолжээ. Уг захирамж болон түүнийг хэрэгжүүлэх холбооны журмуудаар холбооны Засгийн газрын санхүүжилтээр ажил гүйцэтгэх үндсэн болон дэд гэрээлэгчдийн мөрдөх шаардлагыг хатуу тогтоосон байна.

¹⁴ILO. ILO Standards on Forced Labour: The new Protocol and Recommendation at a Glance, 2016.

В. ҮНДЭСНИЙ ХУУЛЬ ТОГТООМЖ

Монгол Улсын Үндсэн хууль (1992)¹⁵ -ийн Арван зургадугаар зүйлийн 4 дэх заалт болон Хөдөлмөрийн тухай хууль (2021)¹⁶-ийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт заасны дагуу тус улсад хэнийг ч албадан хөдөлмөрлүүлж болохгүй. Эрх зүйн байдлаасаа үл хамааран бүх хүн эдгээр заалтын дагуу хамгаалагдана. Энэ нь Монгол Улсад хууль бусаар ажиллаж буй цагаач ажилчдыг ч албадан хөдөлмөрөөс хамгаалах чухал ач холбогдолтой юм.

Мөн Хөдөлмөрийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэгт “Албадан хөдөлмөрлүүлэх гэж аливаа торгууль, шийтгэл ногдуулахаар айлган сүрдүүлэх, хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх замаар хүнийг хүсэл зоригийнх нь эсрэг ажил, үйлчилгээ эрхлүүлэхийг ойлгоно” гэж тодорхойлон, тус зүйлийн 8.3 дахь хэсэгт албадан хөдөлмөрт хамаарахгүй ажил, үйлчилгээг заасан байна. Хөдөлмөрийн тухай хуулийн 2021 оны шинэчилсэн найруулгаар тус хуулийн хамрах хүрээг өргөжүүлж, туслах малчин, гэрийн үйлчилгээний ажилтан, ажиллах хүч нийлүүлэх гэрээгээр ажиллагчдын хөдөлмөр эрхлэлтийн харилцааг зохицуулсан байна. Түүнчлэн ажил олгогч ажилтны мөнгө, эд зүйл, бичиг баримтын эх хувийг барьцаалахыг хориглосон заалтыг шинээр тусгажээ.

Эрүүгийн хууль (2015)¹⁷-ийн 13.13 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт албадан хөдөлмөрлүүлэх гэмт хэргийг “бусдад хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, илт хохиролтой болзол, нөхцөл тулгаж, эсхүл хөрөнгө чинээ, эрүүл мэнд, хөгжлийн бэрхшээлтэй байдал, гэр бүлийн таагүй орчин, амьдрал ахуйн бусад хүнд байдлыг далимдуулан эрхшээлдээ оруулж цалин хөлсгүй хөдөлмөр эрхлүүлсэн” хэмээн тодорхойлж, цалин хөлсгүй гэдгийг албадан хөдөлмөрлүүлсэн гэмт хэргийг тодорхойлох элемент болгосон нь Албадан хөдөлмөрийн тухай Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 29 дүгээр конвенцын 25 дугаар зүйл, мөн тус конвенцын протоколын 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн дагуу эрүүгийн хэрэг гэж үзэж, ял шийтгэвэл зохих хууль бусаар албадан хөдөлмөрлүүлэх гэмт хэргийн хүрээг явцууруулсан байна. Харин тус хууль болон Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль (2012)-д хүн худалдаалах гэмт хэргийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенц, түүний нэмэлт болох Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протоколд нийцүүлэн тодорхойлж, албадан хөдөлмөрлүүлэх зорилгоор хүн худалдаалахыг хамруулсан байна.

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хууль (2010)¹⁸-ийн дагуу Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт Үндэсний хороо хөдөлмөрийн гэрээ болон хөлсөөр ажиллах гэрээ, тэдгээртэй адилтгах бусад гэрээгээр ажиллагчийн цагийн үндсэн цалин (хөлс)-гийн доод хэмжээг тогтоож, эдийн засгийн бүх салбарт мөрдүүлэхээр заажээ.

¹⁵ <https://legalinfo.mn/mn/detail/367>

¹⁶ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16230709635751>

¹⁷ <https://legalinfo.mn/mn/detail/11634>

¹⁸ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=566>

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль (2011)¹⁹ -ийн 9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсэгт заасны дагуу хөдөлмөрийн хувийн бирж нь ажилд зуучлуулсан иргэнээс шууд ба шууд бус байдлаар үйлчилгээний төлбөр авахыг хориглосон.

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль (2012)²⁰-ийн 8 дугаар зүйлд “Хэвлэл мэдээллийн байгууллагын үүрэг хэсэгт хохирогчийн бичгээр гаргасан зөвшөөрөлгүйгээр хохирогчийн тухай мэдээлэх, гадаадын иргэнтэй гэр бүл болоход зуучлах зар сурталчилгаа гаргах болон хүн худалдаалахад хүргэж болохуйц ил болон далд сурталчилгаа явуулахыг хориглоно” гэжээ. Энэхүү хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2-т “хохилогч” гэж “...эрүүгийн хэрэг үүсгэсэн, хохирогчоор тогтоосон эсэхээс үл шалтгаалан хүн худалдаалахын улмаас эрх, эрх чөлөө, ашиг сонирхол нь зөрчигдсөн хүнийг хэлнэ” хэмээн тодорхойлжээ.

Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль (2013)²¹-иар эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах, тэднийг мэдээллээр хангах, дэмжлэг, туслалцаа үзүүлэх эрх зүйн үндсийг тогтоожээ. Тус хуульд 2021 онд нэмэлт, өөрчлөлт орсноор гэрч, хохирогчоос гадна хүний эрх хамгаалагчийг хуулийн хүрээнд хамруулах болсон.²²

Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль (2021)²³-иар Монгол Улсын иргэн гадаадад, гадаадын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсад хөдөлмөр эрхлэх, тэдгээрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулж, зуучлуулагч, ажилтныг хамгаалах тодорхой заалтуудыг тусгасан байна.

Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль (2021)-иар хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлыг тодорхойлохын зэрэгцээ хүний эрх, эрх чөлөөг хөхиүлэн дэмжих, хүндэтгэх, хамгаалах, үйл ажиллагаа явуулах нөхцөлөөр ханган тэдэнтэй хамтран ажиллах, улмаар Комиссын дэргэдэх орон тооны бус Хүний эрх хамгаалагчийн хорооны бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулсан. Уг хуулийн хүрээнд сэтгүүлч албадан хөдөлмөр, хөдөлмөрийн мөлжлөг, хүн худалдаалах гэмт хэрэг зэрэг хүний эрхийн ноцтой зөрчлийн асуудлыг нийгэмд хөндөж, сурвалжлах явцдаа дарамт шахалтад орох, аюул заналхийлэлд өртсөн тохиолдолд эрсдэлийн үнэлгээ хийлгэх, шаардлагатай бол хамгаалалтад орох зэрэг хүний эрхийг хамгаалагчийн хувьд хуулийн хамгаалалтад орох боломж бүрджээ.²⁴

¹⁹ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=563>

²⁰ <https://legalinfo.mn/mn/detail/554>

²¹ <https://legalinfo.mn/mn/detail/9287>

²² <https://legalinfo.mn/mn/detail/9287>

²³ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16390388880621>

²⁴ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16207226850601>

МОДУЛЬ 2

МЭДЭЭЛЛИЙГ ХАЙЖ ОЛОХ НЬ



2.1. ХЭСЭГ - АЖИЛД ЗУУЧЛАХ НЬ

Бүтээлийн тэнцвэртэй, шударга байдлыг хангах нь мэдээж хэцүү ажил юм. Энэ нь хангалттай бэлтгэл, сэдвийн талаарх ойлголт, шаргуу хөдөлмөр, урт хугацааны хичээл зүтгэл шаардана. Фото сэтгүүлч, баримтат кино найруулагч Мими Чакарова²⁵-гийн хэлснээр юуны өмнө сэтгэл санааны бэлтгэл хамгийн чухал юм. Мөн хатагтай Мими Чакарова хэлэхдээ сэтгэл санааны бэлтгэлээс гадна чанартай сурвалжилга өргөн цар хүрээтэй судалгаанаас бүтдэг гэжээ. Иймээс та хийж болох ба хийж болохгүй дараах зүйлийн талаар анхаарч ажиллах ёстой.

Хийж болох ба болохгүй зүйлс



БОЛОХ

Хэвлэл мэдээллээр тухайн цаг мөчид мэдээлж байгаа зүйлсийг уншаад, тааруухан бэлтгэсэн түүх мэдээг хайх. Тухайлбал зохистой хөдөлмөр эрхлэх нөхцөл боломж хомс байдал, зарим салбар дахь зүй бус үйлдэл, хууль тогтоомжийн хийдэл, хохирогч хамгаалал, хохирогчдод үзүүлэх үйлчилгээнд ялгаварлан гадуурхах зэрэг болно.



БОЛОХГҮЙ

Дуулиантай мэдээний хойноос хөөцөлдөх, эсвэл бодит байдлыг гажуудуулсан мэдээ бэлтгэхээр оролдох.



БОЛОХ

Салбарын мэргэжилтнүүдтэй холбогдох. Тухайлбал иргэний нийгмийн байгууллагууд, эрдэм шинжилгээний ажилтнууд, албадан хөдөлмөрийн асуудлаар мэргэшсэн мэргэжилтнүүд.



БОЛОХГҮЙ

Эмзэг бүлгийн хүмүүстэй харьцаж байгаагаар мартаж. Хэчнээн давчуу цагаар ажиллаж байсан ч яарах нь буруу үр дагавар дагуулж болзошгүй юм.



БОЛОХ

Бэлтгэж болох мэдээний боломж (цаг хугацаа, формат, хуулийн болон хувийн эрсдэл, нөөц) түүнчлэн таны болон танд мэдээлэл өгч буй эх сурвалжид хамаарах боломжит үр дагаврыг үнэлэх.



БОЛОХГҮЙ

Таны үүрэг бол үзэгчдэд мэдээлэх болохоос өмгөөлөх биш гэдгийг санах.

²⁵ Хатагтай Мими Чакарова нь Болгар-Америкийн сэтгүүлч, найруулагч юм. Үзэх холбоос: <https://dartcenter.org/bio/mimi-chakarova>

2.2. ХЭСЭГ-МЭДЭЭЛЛИЙГ ХАЙЖ ОЛОХ НЬ

Энэ хэсэгт албадан хөдөлмөрийн нөхцөл байдлын талаар сурвалжилсан жишээнүүд багтсан бөгөөд энэхүү модульд хөдөлмөрлөх эрхийн зөрчлийг дэлгэн харуулахад чиглээгүй болно. Эерэг нийтлэл бүтээл нь хүчтэй үр нөлөө үзүүлж болно. Тухайлбал хөдөлмөрлөх эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлж, зохистой орчин нөхцөлийг бүрдүүлж, ажилд зуучлах, авах харилцаанд шударга зарчмыг хангаж чадвал ажиллах хүчний шилжилт хөдөлгөөн нь үр ашигтай байж болох талаар олон нийтийн хандлагыг сайжруулж болно. Ингэснээр цагаач ажилчдын хөдөлмөр эрхлэлт нь шилжиж явсан болон суурьшихаар очсон улс орны хөгжилд хувь нэмэр үзүүлж, эдгээр улс орны төдийгүй цагаач ажилчдын өөрсдийнх нь аж амьдралд ч сайнаар нөлөөлж болохыг харуулах юм.

Сэтгүүлчид нь бодлого, хууль тогтоомж, бизнесийн үйл ажиллагаанд гарсан эерэг өөрчлөлтийн талаар мөн энэ нь хэдэн мянган хүний амьдралд хэрхэн нөлөөлж болох талаар өгүүлж, олон нийтэд хүргэх боломжтой байдаг.

Энэ хэсгийг сэдвүүдээр ангилсан бөгөөд товч танилцуулга, сурвалжилгын жишээ болон өгүүлэмж бүхий нийтлэл нэвтрүүлгийн эхлэх цэг байж болох асуултыг бичиж орууллаа.

А. ХҮМҮҮСИЙН ТҮҮХИЙГ ӨГҮҮЛЭХ НЬ

Хамгийн баттай өгүүлэмж бол хүмүүс өөрсдийн талаар ярьсан түүх юм. Ярьж хэлсэн зүйлсийг дуулиан болгох хэрэггүй. Зарим шаардлагатай бодит мэдээллийг нэмээд эдгээр баримт, хувь хүмүүсийн бусдад мэдүүлэхийг хүссэн зүйлсийг өөрсдөөр нь яриулж болно. Дэмжих бүлгүүд таныг хэн нэгэн тухайлбал даван туулж гарсан хүнтэй холбож өгч болно. Хэрэв тэд танаас хүсвэл хувийн мэдээллийг нь хамгаалах ёстой. Хүмүүсийн ашиг сонирхлыг хөндсөн түүхүүд байнга өргөн хүрээнд түгдэг бөгөөд тухайн асуудлын талаарх ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлж, өөрчлөлтийн төлөөх олон нийтийн шахалт, шаардлагыг бий болгодог.

2017 ОНЫ ХАМГИЙН ИХ УНШИГДСАН МЭДЭЭ ЮУ ВЭ? “МАНАЙ ГЭР БҮЛИЙН БООЛ”²⁶ НЭРТЭЙ АТЛАНТИК СЭТГҮҮЛД ГАРСАН НИЙТЛЭЛ

– Рик Эдмондс

Филиппин–Америкийн зохиолчийн цагаач эцэг эхээ хэрхэн дагаж Америкийн Нэгдсэн Улсад ирсэн “Лола”-гийн тухай өгүүлжээ. Тэрээр болж өнгөрсөн зүйлсийг ойлгоод ичиж санаа зовсондоо өсөж том болохын хэрээр хожим насанд хүрсэн ч үүнийг нуусан тухай өгүүлдэг. Нийтлэл маш хувийн шинжтэй, гэм буруугаа хүлээсэн гэмээр агуулгатай. Нийтлэлээ бичиж дуусгаад хэвлэгдэхээс өмнө 57 настай Тизон нь өвчний улмаас гэнэт нас баржээ.

²⁶ Edmonds, R. *The best-read story of 2017? It's the Atlantic's 'My Family's Slave'*. Poynter, 2017.

Таны эрэлхийлэх гол асуулт:

- Ажилчдыг ажилд хэрхэн элсүүлсэн бэ?
- Тэд ямар ажил хийдэг вэ?
- Тэд ямар замаар ирсэн бэ?
- Ажлаас гадуурх амьдралын орчин нөхцөл ямар байсан бэ?
- Хэрэв тэд албадан хөдөлмөрт өртөж байсан бол яаж эрх чөлөөтэй болсон бэ?
- Тэдний ойр тойронд байсан хүмүүс ямар хариу үйлдэл үзүүлсэн бэ?

Дээрх сэтгүүлд гарсантай төстэй жишээг Монгол Улсын хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээс ч олж болно. Хөдөлмөрлөх эрх нь ноцтой зөрчигдөж буй ажиллагчид өөрсдийн түүхээсээ хуваалцаж, энэ талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацсан жишээнээс танилцуулъя.

Монголын үндэсний олон нийтийн радиогийн 2014 оны 2 дугаар сарын 24-ний өдөр цацагдсан мэдээгээр²⁶ уул уурхайн салбарт байгууллагын эзнээс хамааралтай хөдөлмөрийн мөлжлөг, дарамт, цалингийн тэгш бус хуваарилалт, ёс зүйгүй харилцаан дунд Монгол ажиллагчид тэвчээр заан ажиллаж байгааг өгүүлжээ. Энэ мэдээнд ажиллагчид гэрээсээ хол уурхайд очиж ажилладаг, ажлын нөхцөл байдлаа сайжруулах шаардлага тавих үед хүний нөөцийн менежер, компанийн зүгээс “ажилгүй болгож чадна шүү” хэмээн дарамталдаг, эргээд тэд цалин, орлогогүй болохгүйн тулд тэсэж, тэвчин ажлаа үргэлжлүүлэн хийсээр байдаг тухайгаа өгүүлжээ.

Дараагийн жишээ бол хууртагдан, хүний наймааны золиос болж, хүчээр биеийг нь үнэлүүлсэн эмэгтэйчүүдийн түүх юм. 2020 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн “Өнөөдөр” сонинд нийтлэгдсэн “Бэлгийн мөлжлөгтэй тэмцэхэд бэнчин дутаж байна” өгүүлэлд²⁷ хохирогч эмэгтэйчүүдийн түүхийг өгүүлжээ. Энэ өгүүлэлд “Хохирогчдын мэдээлж буйгаар Н гэгч анх зургаан эмэгтэйг хуурч мэхлэн Малайз Улсад аваачиж улмаар хүчээр биеийг нь үнэлүүлсэн байна. Хууртсанаа мэдсэн хохирогчдын хоёр нь тус улсын хүний эрхийн байгууллагаас тусламж авч, оргож боссор ямар ч гэсэн эх орондоо ирсэн бол харин дөрөв нь Малайз Улсад аврал эрсэн хэвээр үлджээ.” гэжээ. Өгүүлэлд цааш нь энэ мэт хууль бус хөдөлмөр зуучлал, хил дамнуулан албадан хөдөлмөрлүүлсэн гэмт үйлдэлд хууль сахиулах байгууллагын хүчин чармайлт, хамтын ажиллагаа, хөрөнгө санхүүжилт ихээхэн хэрэгцээтэй байгаа асуудлыг хөндсөн байна.

ХҮМҮҮСИЙН ТУХАЙ ӨГҮҮЛСЭН ЖИШЭЭ

Kermani, S. 2018. *Tayyaba abuse case shines light on Pakistan's child maids*. Available at: <https://www.bbc.co.uk/news/world-asia-44397432>

Lekas Miller, A. 2015. *Migrant Workers Are Bringing a Taste of Home to Beirut*. Munchies. Available at: https://munchies.vice.com/en_us/article/mgxnwq/migrant-workers-arebringing-a-taste-of-home-to-beirut

²⁶ <http://www.mnb.mn/i/17895>

²⁷ Д.Мягмаржаргал, *Бэлгийн мөлжлөгтэй тэмцэхэд бэнчин дутаж байна*, *Unuudur.mn*, 2020.04.22

Б. ХӨДӨЛМӨР БА АЖЛЫН БАЙР

Зохистой хөдөлмөр нь ажил, хөдөлмөр эрхэлж амьдарч буй хүмүүсийн хүсэл эрмэлзлэлийн илэрхийлэл юм. Зохистой хөдөлмөр хөтөлбөрийн дөрвөн тулгуур нь хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал, хөдөлмөрлөх эрх, нийгмийн түншлэл билээ. Ажиллагчдыг ажилд авах нөхцөл нь эдгээр хүчин зүйл бүрийг хэрэгжүүлэхэд нөлөөлж болзошгүй бөгөөд ажилд зуучлах, авах харилцаанд шударга байдлыг хангах зарчим бүх хүнд үйлчлэх ёстой. Эдийн засгийн олон салбарт хөдөлмөрлөх эрхийн зөрчил гарч болох бөгөөд цаашилбал энэ нөхцөл байдал нь албадан хөдөлмөрт хүргэхээр байж болно. Энэ нь ихэвчлэн далд байх магадлалтай тухайлбал гэрийн үйлчлэгчийн ажил, алслагдсан орон нутагт байрлалтай хөдөө аж ахуй, уул уурхай, загас агнуурын салбарт, эсвэл өдөр тутмын амьдралд ойр хоол үйлдвэрлэл, зочид буудлын үйлчилгээнд байх боломжтой юм.

Таны эрэлхийлэх гол асуулт:

- Танай бүс нутаг дахь эдийн засгийн болон хөдөлмөр эрхлэлтийн үндсэн салбарууд юу вэ?
- Ажиллагчид ажилд орохын тулд ямар алхам хийх шаардлагатай вэ? Тэд ажилд зуучлуулсны төлбөр хураамж төлдөг үү? Урьдчилгаа төлбөр нь ажиллагчдыг хэрхэн “өрийн төлөөс” болгож болох вэ?
- Ажил олгогч, ажилтнууд хөдөлмөрлөх эрхээ мэдэж байна уу?
- Хөдөлмөрийн ямар нөхцөл байна вэ?
- Ажлын байранд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар ямар мэдээлэл өгдөг вэ?

АЖЛЫН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ТАЛААР ӨГҮҮЛСЭН ЖИШЭЭ

Webb, S. 2014. The side of Dubai that they DON'T want tourists to see: Photos show desperate conditions endured by migrant labourers forced to work in 50C heat for a pittance. DailyMail.

Available at: <http://www.dailymail.co.uk/news/article-2859734/The-Dubai-DON-T-want-tourists-Photos-desperate-conditions-endured-migrant-labourers-forced-work-50C-heat-pittance.html>

Obrero. n.d. Homepage. Norman Zafra presents an interactive documentary platform on the recruitment of Filipino workers in the construction sector in New Zealand. Available at: www.obrerofilm.com

В. БИЗНЕС БА ЭДИЙН ЗАСАГ

Албадан хөдөлмөр болон ажилд зуучлах, авах харилцаанд шударга бус хандах явдлаас үүдэн маш ихээр хууль бус ашиг орлого олдог. Олон улсын хөдөлмөрийн байгууллагын хийсэн судалгаагаар орчин цагийн боолчлолоос жилд 150 тэрбум долларын ашиг олдог. Сэтгүүл зүйн бүтээл, сурвалжилга нь эдгээр асуудлын цаадах далд эдийн засгийг ил болгож, ажил олгогч, бизнес эрхлэгчдийг өөрсдийнхөө үйл ажиллагаанд болон нийлүүлэлтийн сүлжээнийхээ хүрээнд албадан хөдөлмөр ашиглах эрсдэлийг шийдвэрлэх, ажилд зуучлах, авах харилцаанд шударга байдлыг хангах зарчим, зохистой хөдөлмөр эрхлэх нөхцөл бүрдүүлэхийг дэмждэг байна.

Таны эрэлхийлэх гол асуулт:

- Ажилд зуучлах, авах харилцаанд шударга бус хандах, хүн худалдаалах, албадан хөдөлмөрийн цаана эдийн засгийн ямар хөшүүрэг байна вэ?
- Эдгээрийг хэрхэн болиулж, даван туулах вэ?
- Бизнес эрхлэгчид үйл ажиллагаандаа зохистой хөдөлмөр эрхлэх нөхцөлийг дэмжих чиглэлээр юу хийж байна вэ?
- Төрийн болон хувийн хэвшлийн ажил олгогчид өөрсдийн нийлүүлэлтийн сүлжээн дэх магадлан шинжилгээг хэрхэн хийдэг вэ?
- Аж ахуйн нэгж, байгууллагын амлалт нь бодит байдалд бизнесийн үйл ажиллагаанд хэрхэн хэрэгжиж байна вэ?
- Хэрэглэгчдийн зүгээс үзүүлдэг шахалт ажиллагчдын хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулахад нөлөөлсөн үү?

МӨНГӨНИЙ ТАЛААР ӨГҮҮЛСЭН ЖИШЭЭ

CNN. n.d. Working off debt in Cambodia's brick kilns. Available at: <https://edition.cnn.com/videos/world/2017/07/26/cfp-cambodia-brick-kiln.cnn>

Howard, N. 2017. When NGOs save children who don't want to be saved. Al Jazeera. Available at: <https://www.aljazeera.com/indepth/opinion/2017/04/ngos-save-children-do-saved-170425101830650.html>

Г. ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨН

Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас гаргасан тооцоогоор өнөөдөр дэлхий дахинд 164 сая цагаач ажилчид байна²⁸. Илүү сайн боломж эрэлхийлэн шилжин суурьшиж буй хүмүүс болон тэдний гэр бүлийнхний нүүр тулдаг хүнд хэцүү сонголтыг энэ талаарх түүхүүд онцлон харуулж чадна. Шилжилт хөдөлгөөний тухай мэдээ нь улс орнуудын эдийн засагт цагаач ажилчдын оруулж буй эерэг хувь нэмрийг харуулж, нийтэд түгсэн хэвшмэл ойлголт, гадаадынхныг үзэн ядах үзлийг даван туулахад тусална.

Таны эрэлхийлэх гол асуулт:

- Хүмүүс яагаад гэрээсээ хол ажиллах боломжийг хайдаг вэ?
- Цагаачлах эрх зүйн ямар боломж байна вэ?
- Хүмүүс хэрхэн зорчдог вэ?
- Шилжилт хөдөлгөөнийг хэн удирддаг вэ?
- Шилжилт хөдөлгөөний хууль ёсны, эсвэл тогтсон маршрут гэнэт хаагдвал юу болох вэ?
- Цагаач ажилчдыг улс орнууд хэрхэн хүлээж авдаг вэ? Тэдэнд шударга ханддаг уу?

²⁸ ILO. *ILO global estimates on migrant workers*, 2018.

ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНИЙ ТАЛААР ӨГҮҮЛСЭН ЖИШЭЭ

BBC. 2004. Billy's journey started in Senegal and ended more than five months later in Italy. Available at: <http://news.bbc.co.uk/1/hi/world/africa/3520404.stm>

Tesorero, A. 2017. Indian plumber sings music idol's song, becomes a champ in Dubai. *Khaleej Times*. Available at: <https://www.khaleejtimes.com/nation/dubai/indian-plumber-sings-music-idols-song-becomes-a-champ-in-dubai>

Д. ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТ

Хүнийг хүйс, арьс өнгө, үндэс, угсаа, хөгжлийн бэрхшээл зэргээр нь ялгаварлан гадуурхах явдал гардаг. Ялгаварлан гадуурхалтын бүх хэлбэр нь ажилд зуучлах, авах харилцаа болон хөдөлмөрийн нөхцөлд нөлөөлж болно. Заримдаа ажиллагчид тодорхой угсаатны бүлэг болон нийгмийн анги давхаргад харьяалагдсаныхаа, эсвэл бүр улс төрийн үзэл бодлынхоо улмаас албадан хөдөлмөрт өртөх ч эрсдэлтэй. Мөн хөдөлмөрийн харилцаанд эмэгтэй цагаач ажилчид дотооддоо болон гадаадад ялгаварлан гадуурхалтад өртдөг.

Ажилд зуучлах, авах ажиллагаа, албадан хөдөлмөрийн асуудлыг харахдаа ялгаварлан гадуурхалтыг харгалзан үзэх нь чухал юм. Ажлын байран дахь ялгаварлан гадуурхалтыг шийдвэрлэх тухай болон ажил хөдөлмөрт адил тэгш хандахыг дэмжсэн мэдээ нь олон нийтийн мэдлэг, ойлголтыг дээшлүүлж, сэтгэлгээг өөрчлөх боломжтой.

Таны эрэлхийлэх гол асуулт:

- Зарим хүн ажилд орох боломж, эсвэл ажилд зуучлах, авах үйл явцад хөдөлмөрийн нөхцөлтэй холбоотой ялгаварлан гадуурхалтад өртдөг үү? Аль салбарт вэ?
- Ажлын байрандаа тэгш байдлыг хангах талаар хүчин чармайлт гаргадаг уу?
- Дотоодын болон олон улсын шилжилт хөдөлгөөний нөлөө зарим хүнд өөрөөр тусдаг уу?
- Зарим хүн албадан хөдөлмөрт өртөх илүү эрсдэлтэй байдаг уу? Хүүхэд? Эмэгтэйчүүд? Эрэгтэйчүүд? Нутгийн уугуул иргэд?
- Эмэгтэй, эрэгтэй хүмүүс ажил хөдөлмөр эрхлэхэд ижил тэгш эрхтэй юу? Тэд эрхээ адилхан мэддэг үү?

ЯЛГААТАЙ БАЙДЛЫН ТАЛААР ӨГҮҮЛСЭН ЖИШЭЭ

Salameh, D. 2018. *Female Migrant Workers: Long-Distance Mothers*. Available at: <https://www.7iber.com/society/female-migrant-workers-long-distance-mothers/>

Seiff, A. 2017. "If You Have Money, You Can Think Whatever You Want". *MBright*. Available at: <https://brightthemag.com/health-nepal-women-travel-stigma-work-ba687e07a2e3>

Е. ХУУЛЬ САХИУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА БА ГЭМТ ХЭРЭГ

Ихэнх улс орны шударга ёсны тогтолцоо нь хүн төрөлхтний хамгийн зүй бус явдлын заримыг илчилж гаргадаг билээ. Энэ нь хөдөлмөрлөх эрхийн зөрчил дээр ч харагддаг. Хэрэв танай улс орон хөдөлмөрлөх эрхийн зөрчлийн эсрэг арга хэмжээ авбал энэ асуудлыг хариуцаж буй мэргэжлийн агентлаг эсвэл цагдаагийн байгууллага зэрэг албаны эх сурвалж, хүмүүстэй холбоо тогтоогоорой. Хуультай хэр нь хэрэгжилт хангагдахгүй байгаа бол яагаад хэрэгжихгүй байгаа талаар асуугаарай.

Таны эрэлхийлэх гол асуулт:

- Танай оронд холбогдох ямар хууль тогтоомж мөрдөгдөж байна?
- Хуулийн хэрэгжилтийг хангуулах үүргийг хэн хүлээдэг вэ?
- Тэд үүнийгээ хэрхэн хэрэгжүүлж байна вэ?
- Хууль хэр сайн хэрэгждэг вэ?
- Ажиллагчдын эрхийг зөрчсөн хүмүүст ямар үр дагавар учрах вэ?

ХУУЛЬ ЁСНЫ ТАЛААР ӨГҮҮЛСЭН ЖИШЭЭ

Agence France–Presse. 2017. Thai general among officials jailed for human trafficking. *The Nation*. Available at: <https://www.nationthailand.com/national/30321238>

Al Jazeera. 2017. Qatar approves new bill to protect foreign workforce.

Available at: <https://www.aljazeera.com/news/2017/10/qatar-approves-bill-protect-foreign-workforce-171026064750875.html>

Ё. МЭДЭЭЛЭЛ, БОЛОВСРОЛ, СУРТАЛЧИЛГАА

Хөдөлмөрийн харилцаан дахь зөрчлийг арилгах, хүмүүсийн зохистой хөдөлмөр эрхлэх боломжийг дэмжих талаар өөрчлөлт хийж буй хүмүүсийн үйл хэргээс санаа авч мэдээ бэлтгэж болно.

Таны эрэлхийлэх гол асуулт:

- Хүмүүст эрхийнх нь талаар мэдээлэхийн тулд юу хийж байна вэ?
- Зүй бус үйлдэлд өртөгчдийн төлөө хэн ажиллаж байна вэ?
- Албадан хөдөлмөрт өртсөн, эсвэл цагаачилсан хүмүүсийг олон нийт дэмжиж, эсвэл эсэргүүцэл илэрхийлж байна уу?
- Нөлөөллийн бүлгүүдийн дэмжиж буй бодлогод сөрөг нөлөө бий юу?
- Олны танил, алдартай хүмүүсийн дэмжлэгтэйгээр олон нийтийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэхэд ямар үүрэг гүйцэтгэдэг вэ?

Үүний нэг жишээ бол олны танил жүжигчин тоглолтын үеэр “Охиноо гадаадад явуулаад их мөнгө олох боллоо гээд баярлаад л байсан. Гэтэл явсан хойно нь ядаж аль улс руу явсныг ч мэдээгүй байдаг байна шүү...” хэмээн хэлсэн үгийг эшлэл болгож оруулсан “Иргэдийг хөдөлмөрийн мөлжлөгт зуучилдаг газруудад гав хэрэгтэй” гарчигтай өгүүлэл²⁹ юм.

²⁹ Д.Идэржаргал. *Иргэдийг хөдөлмөрийн мөлжлөгт зуучилдаг газруудад гав хэрэгтэй*. *24tsag.mn*. 2014.11.30.

Өгүүллийг www.24tsag.mn сайтад 2014 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр “Хүний эрхийн олон улсын өдөр”-т зориулан, “Монгол хүний хөдөлмөрлөх эрхийг хамгаалъя” цувралын хүрээнд нийтэлжээ. Уг өгүүлэлд “Ти энд Ди Си” компани нь Япон Улсад иргэдийг зуучилсан бөгөөд нийт 52 залууг илгээж, тэднээс 155 сая төгрөгийн зуучлалын хураамж авчээ. Гэвч зарим нь ажлын байргүй шалтгаанаар орлогогүй буцаж ирсэн, үлдсэн 22 залуу нь маш хүнд хөдөлмөр эрхэлж байсан боловч бага цалин хөлс авч байсан нь дээрх зуучлагч компанийн захирал гэгч Япон эзэнтэйгээ нууцаар тохиролцож, хүн бүрийн цалин хөлснөөс сар бүр сая төгрөгийг суутган авч байсантай холбоотой тухай өгүүлдэг. Энэ мэтчилэн хүмүүсийг залилсан үйл ажиллагаа явуулж буй зуучлалын компанийн эрхийг цуцлах, эрх зүйн орчинг сайжруулах тухай асуудлыг хөндсөн олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх зорилготой өгүүлэл юм.

Монгол Улс хөгжиж буй орны хувьд хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь соён гэгээрүүлэх үүргийг энэ мэт асуудалд тууштай хэрэгжүүлэх шаардлагатай болдог. Иймд зүй бус үйлдэлд өртсөн, ийм эрсдэлтэй иргэдэд сэрэмжлүүлэх мэдээлэл чухал бөгөөд үүний дотор нэн тэргүүнд холбоо барих, хандах байгууллага, тэдэнтэй холбоо барих мэдээллийг түгээж байх нь сэтгүүлчдийн хувьд үүргээ биелүүлж буй нэгэн чухал алхам болох юм. Үүнтэй холбоотойгоор сэтгүүлчдэд энэ чиглэлээр бичиж сурвалжлахад хэрэг болохуйц дараах нэмэлт мэдээллийг оруулав.

Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл шуурхай удирдлагын төв 2010 онд байгуулагджээ. Тус төв нь иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас гэмт хэрэг, зөрчил, гамшиг осол, гал түймэр, эмнэлгийн яаралтай тусламжийн талаарх мэдээллийг хүлээн авах, цагдаа, онцгой байдал, эмнэлгийн түргэн тусламжийн хөдөлгөөнт хэсэг, бүлгүүдийг шуурхай удирдлага, зохицуулалтаар хангах, үйл ажиллагаанд нь хяналт тавих, мэдээ мэдээллийг нэгтгэн боловсруулах, төрийн зохих байгууллагуудыг шуурхай мэдээллээр хангах үндсэн чиг үүрэгтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна. Үүний дотор албадан хөдөлмөр өртсөнөөр гэмт хэрэг, зөрчлийн хохирогч болох, хөдөлмөрийн мөлжлөгт өртөх зэрэг гэмт үйлдлүүдийн талаар дуудлага, мэдээлэл өгөх боломжтой юм. Тус төвийн тусгай дугаарын “102” утсанд иргэн, хуулийн этгээдээс хандсанаар гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй дуудлага, мэдээллийг үнэн зөв, бүрэн хүлээн авч бүртгэн, холбогдох цагдаагийн байгууллагад шуурхай дамжуулж, хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд арга хэмжээ авч, ажилладаг байна³⁰.

Гадаад харилцааны яамнаас Монгол Улсын иргэд гадаадад түр болон удаан хугацаагаар зорчих хугацаандаа гэмт хэрэг, зөрчилд холбогдох, аваар осолд өртөх, эд хөрөнгө, эрүүл мэнд, амь насаараа хохирох тохиолдолд тэдгээрийн эрх ашгийг хамгаалах, эдгээр нөхцөл байдлаас урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээллийг түгээх зорилгоор цахим сайт³¹ ажиллуулдаг байна. Түүнчлэн консул, консулын үйлчилгээний талаар ерөнхий ойлголт өгөх, хилийн чанадад байхдаа анхаарах зүйлсийн талаар гадаадад зорчих гарын авлага болон цахим товхимол бэлтгэжээ³².

³⁰ <http://eincenter.police.gov.mn/>

³¹ www.consul.mn

³² <http://www.consul.mn/file/GariinavлагаConsul.mn.pdf>

МЭДЛЭГ, ОЙЛГОЛТ НЭМЭГДҮҮЛЭХ МЭДЭЭНИЙ ГАДААД ЖИШЭЭ

<http://edition.cnn.com/2017/06/21/africa/mauritania-slavery-biram-dah-abeid/index.html>

Actors lend their support to a global campaign to end modern slavery. Available at: http://www.ilo.org/global/about-the-ilo/newsroom/news/WCMS_416433/lang-en/index.htm

2.3. ХЭСЭГ- ОЛОН НИЙТИЙН ДЭМЖЛЭГ АВАХ НЬ**А. ДЭМЖЛЭГ ОЛОХ НЬ**

Хэрэв та цаг хугацаа, нөөц шаардсан, түүнчлэн эсэргүүцэж буй хүмүүсийн анхаарлыг татахуйц мэдээ, сурвалжилга бичихээр зорьж байгаа бол редактораас зөвшөөрөл авах нь хэцүү ажил байж мэдэх юм.

Энэ тохиолдолд уг ажил манай хэвлэл мэдээллийн байгууллагын үнэ цэнийг нэмэгдүүлэх чухал ажил гэдгийг редактораа ойлгуулж ятгах ганц сонголт л танд байна. Та удирдлагадаа дараах зүйлийг сануулж болно.

- Сэтгүүл зүйн цөм нь эрэн сурвалжлахад оршино.
- Эрэн сурвалжлах сайн мэдээ нь хэвлэл мэдээллийн байгууллагын өнгө төрхийг өсгөж, байр суурийг бэхжүүлж, орлогыг нэмэгдүүлнэ.
- Сурвалжилга нь ер бусын өндөр чанартай болох ба олон нийтийн анхаарлыг татаж, нэр хүндийг өсгөнө.
- Танай байгууллага тухайн сэдвийг “өмчилж” чадна. Өөрөөр хэлбэл тухайн сэдвийг өгүүлэх үндсэн цэг болно. Бусад хүмүүс хамаарах мэдээг цааш үргэлжлүүлнэ.
- Мэдээг шагналд нэр дэвшүүлэх боломжтой юм.

Б. САНХҮҮЖИЛТ

Эрэн сурвалжлах ажилд зарцуулах нэмэлт цаг хугацаа, нөөц хайхдаа ажилтнуудын цаг, тээврийн болон байрны зэрэг бусад бүх зардлыг төлөвлөх нь чухал байдаг.

Сурвалжилга, мэдээ бэлтгэхдээ гадны санхүүжилт хайгаарай. Тухайлбал олон улсын төрийн бус байгууллага шилжилт хөдөлгөөний талаар цуврал мэдээ бэлтгэхээр бусад улс руу явж буй сурвалжлагчийн зардлыг төлөхийг зөвшөөрч магадгүй юм. Заримдаа уралдааны ялагчдад тэтгэлэг олгогддог.

Үйл явдлын нэг талыг барьсан, зөвхөн санхүүжүүлэгчийн хүссэн зүйлийг мэдээлэх эрсдэлтэй байдгийг анхаарах хэрэгтэй. Хэвлэл мэдээллийн байгууллага нь редакцын хяналтаа хадгалж, юуг нийтлэх вэ гэдгээ эцэслэн шийддэг байх нь чухал юм.

В. ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН БУСАД ХЭРЭГСЭЛТЭЙ ХАМТРАХ НЬ

Хэвлэл мэдээллийн бусад байгууллагуудтай хамтран ажилласнаар зардлаа багасгаж, үр нөлөөгөө нэмэгдүүлэх боломжтой. Гардиан, Вашингтон Пост зэрэг олон улсын хэмжээний хэвлэл мэдээллийн байгууллагууд том үр дүнд хүрэхийн тулд ингэж ажилласан туршлагатай. Мөн жижиг хэвлэл мэдээллийн байгууллагууд ч гадаад хамтын ажиллагаагаа хөгжүүлэх боломжтой юм.

Бүтээл нийтлэх цаг нь болоход хамтын хүчин чармайлт хэрэгцээтэй байдаг. Өөр төрлийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр магадгүй өөр өөр улс оронд үйл явдлын мэдээ, сурвалжилгыг нэгэн зэрэг нийтэлснээр үр нөлөө нь илүү байж, үзэгчдийг татах боломжтой болно.

Дэлхийн эрэн сурвалжлах сэтгүүл зүйн сүлжээ нь хүн худалдаалах гэмт хэргийн эх сурвалждаа хэд хэдэн сонирхолтой хамтын ажиллагааны боломжийг тодорхойлсон байна.

Г. ГАДААД ДЭМЖЛЭГ

Сурвалжилга бэлтгэхдээ редакцын гадна болон дотоодоос аль алинаас нь дэмжлэг авч болно. Боломжит хувилбарууд:

- Сонгогдсон улс төрчид
- Бизнесийн лидерүүд
- Хууль сахиулах байгууллагын албан тушаалтнууд
- Төрийн бус байгууллага болон нийгэмд чиглэсэн кампанит аяны удирдагчид
- Эрдэмтэн, мэргэжилтнүүд
- Олны танил, алдартай хүмүүс

Мэдээ сурвалжилгынхаа зорилгыг тайлбарлаж, тэднээс дэмжлэг хүсээрэй. Тэдний зургийн хажууд дэмжиж буйг нь илэрхийлсэн цөөн хэдэн өгүүлбэр нийтлээрэй. Энэ нь таныг олон нийтийн зүгээс дэмжлэг авч байгааг бусдад харуулах болно.

МОДУЛЬ 3

ҮЙЛ ЯВДЛЫГ БАРИМТЖУУЛАХ НЬ



3.1. ХЭСЭГ – БИЧГЭН БОЛОН БАРИМТАТ ЭХ СУРВАЛЖ

А. БАРИМТ, ДҮРСЛЭЛ

Баримт нь бүх эрэн сурвалжлах сэтгүүл зүйн үндэс юм. Ихэнхдээ баримт нь хуудас дээрх хуурай тооноос өөрцгүй ч, зөв ойлгуулж, тайлбарласнаар сонирхол татахуйц мэдээллийг ил болгож чадна. Баримт сэлтэд дурлаж сурах хэрэгтэй. Албан ёсны статистик, хуулийн зохицуулалт, шүүхийн шийдвэр болон бусад баримт бичиг, компанийн хэвлэмэл бүтээл, сонины нийтлэл зэрэг албан ёсны өндөр ач холбогдолтой баримт сэлт, бичгийн эх сурвалжийг хайж олоорой.

Б. ГЭРЭЛ ЗУРАГ, ВИДЕО

Гэрэл зураг, тэр дундаа дүрс бичлэг орчин үеийн нийтлэл, нэвтрүүлгийн чухал хэсэг юм. Гэхдээ албадан хөдөлмөр болон ажилд зуучлах, авах харилцаанд шударга бусаар хандах явдал нь ихэвчлэн далд явагддаг учраас гэмт хэрэг үйлдсэн этгээд болон үр дагавар хүртэгч тал хоёулаа танигдахыг хүсэхгүй байх нь их.

Хэрэв хэн нэгэн зураг авхуулахыг зөвшөөрсөн (эсвэл дүрс бичлэгт орох) боловч танигдахгүй байхыг хүсвэл зураг авах үедээ хэн болохыг нууцлах нь дээр юм. Тухайлбал эвлүүлэг хийх, мэдээг бэлтгэх явцдаа дүрсийг бүдгэрүүлэх, нуух зэрэг зураг авалтын дараах техник ажиллагаанд найдахаас илүү сүүдэртэй хэсэгт зураг авах, ярилцагчийн гарыг харуулж дүрс бичлэг хийх зэрэг аргыг хэрэглэж болно.

Хэрэв танд эх зураг нь олдохгүй бол юу хийж болох вэ?

- Та зургийн санд бүрдсэн зургаа ашиглаж болох хэдий ч энэ нь таны мэдээнд нийцэхгүй байж болно.
- Та гар зураг, зурмал зураг, уран зураг зэрэг дүрслэх урлагийн тусламжтайгаар мэдээгээ дүрсжүүлж болно.
- Та мэдээгээ ямар ч зураг, дүрслэлгүй үлдээж, яагаад ингэснээ уншигчдад тайлбарлаж болно.

Зураг, дүрс чухал үүрэгтэй ч мэргэжлийн чадвар болон нөөц дутагдсанаас болж гэрэл зургаа болхи засварлахад хүрч, эцэстээ үзэгчдэд ихээхэн таагүй сэтгэгдэл төрүүлдэг.

3.2. ХЭСЭГ - АЮУЛГҮЙ БАЙДАЛ

А. ЁС ЗҮЙТЭЙ СЭТГҮҮЛ ЗҮЙН ЗАРЧИМ

Сурвалжилга, бүтээлийнхээ турш аюулгүй байдлыг хангах зарим нэн чухал зөвлөгөөг энд оруулав.

Алдаагүй мадаггүй байдал

Зөвхөн шалгаж, дахин нягталж, үнэн гэдгийг нь мэдэж авсан баримтыг ашиглана. Бусад бүх зүйлсийг нотлох, ялгаж салгах нь зүйтэй. Сурвалжилга, бүтээлээрээ нотолж буй зүйлс алдаа мадаггүй байх ёстой гэдэгт анхаарах хэрэгтэй. Ямар нэгэн дүгнэлт бүү хийгээрэй. Өөрийн боломждоо нийцүүлж сурвалжилна. Хэрэв ямар нэг эмзэг асуудлыг хөндөж буй бол та юу олж харж байгаагаа, таны эргэн тойрны хүмүүс танд юу гэж хэлснийг л оруулаарай. Задлан шинжилгээ, тайлбар, таамаглал зэргийг өөр эх сурвалжтай асуудлыг том дүр зургаар харж чаддаг хүмүүст үлдээх нь зүйтэй юм.

Үл итгэх байдал

Нөхцөл байдлын талаар танд өгөгдсөн бүх мэдээллийг шинжилнэ. Таны хөндөж буй эмзэг сэдэв бүхий мэдээ сурвалжилгад хамааралтай хэн нэгэнтэй хийсэн ярилцлагыг бичиж авах талаар бодож үзээрэй. Хожим нь тэд таны бүтээлийг няцаахаар дарамт шахалт үзүүлж магадгүй бөгөөд та бичлэг, тэмдэглэлээ шүүхэд өгөх хэрэгтэй болж магадгүй юм.

Тэнцвэртэй байдал

Бүх талын үзэл бодлыг идэвхтэй эрэлхийлнэ. Хэрэв тэд тантай ярилцахгүй эсвэл тэдэнтэй холбоо барьж чадахгүй болбол албан ёсны цахим сайт болон мэдээллийн агентлаг зэргээс хүлээн зөвшөөрөгдөхүйц эх сурвалжийг хайж олоорой. Хэрэв чадаагүй бол “Ямар шалтгааны улмаас мэдээллийн эх сурвалжид хүрч чадаагүй” талаар тайлбарлаарай.

Шүүгч, өмгөөлөгч, эсвэл хүний эрхийн идэвхтэн шиг байх хэрэггүй. Үүнийг танд зөвлөгөө өгч, дүн шинжилгээ хийж чадах мэргэжилтнүүдэд үлдээх нь зүйтэй юм.

Шударга байдал

Зөрчилдөж буй талуудын аль нэгний санал бодлыг дэмжин сурталчилж болохгүй.

Нэг тал нь сайн (хүчтэй, баатарлаг, шийдэмгий, зөв), нөгөө тал нь муухай (муу, сул дорой, аймхай) гэдэг байдлаар үг хэллэг (ихэвчлэн тэмдэг нэр) бүү ашиглаарай.

Түгээмэл хэрэглэгддэг бөгөөд нийгмийн нэг хэсгийг зориудаар ялгаварлан гадуурхах санаагүй үг хэллэг заримдаа бусдыг нь гомдоож болзошгүйг хүлээн зөвшөөрөөрэй. Та өөрөө “овог аймгийн” эсвэл “уугуул оршин суугч” гэх мэтээр хэлүүлэхийг хүсэхгүй байлгүй. Иймд бусад хүмүүст хүндэтгэлтэй хандах хэрэгтэй. Тэд өөрсдийгөө яаж тодорхойлуулах хүсэлтэйг олж мэдээрэй.

Сурвалжилга, бүтээлд таны хувийн өрөөсгөл хандлага туссан бол хүлээн зөвшөөрч, арилгах хэрэгтэй³³.

Монголын хэвлэл мэдээллийн ёс зүйн дүрэм³⁴-тэй танилцаарай.

Б. ХУВИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Тэнцвэртэй, бодитой байдлаар сурвалжилсан ч ялангуяа албадан хөдөлмөр болон ажилд зуучлах, авах харилцаанд шударга бус байдлын талаар сурвалжилж буй сэтгүүлчид эрсдэлд ордог. Та эрүүгийн гэмт хэргийн бүлэглэл, нөлөө бүхий хүмүүс, түүнчлэн Засгийн газрын зүй бус үйлдлийг илчлэх магадлалтай. Үүний хариуд айлган сүрдүүлэлт, дарамт шахалтаас эхлээд бодит хүчирхийлэл, хууль бусаар баривчлах, дур мэдэн цагдан хорих зэрэг явдал ирж болзошгүй юм. Та анхааралтай, бэлтгэлтэй байх хэрэгтэй.

³³ Ethical Journalism Network. [Five-point guide for migration reporting](#), 2018.

³⁴ <http://www.mediacouncil.mn/p/7>

ЭХ СУРВАЛЖ

Committee to Protect Journalists. 2012. *Journalist security guide*. Available at: <https://cpj.org/security/guide.pdf>

Council of Europe. n.d. *Platform to promote the protection of journalism and safety of journalists*. Available at: <https://www.coe.int/en/web/media-freedom>

IFJ. n.d. *Safety*. Available at: <https://www.ifj.org/what/safety.html>

IFJ. n.d. *Gender Equality*. Available at: <https://www.ifj.org/what/gender-equality.html>

INSI. n.d. *INSI Safety Code*. Available at: <https://newssafety.org/about-insi/insi-safety-code/>

UNESCO. n.d. *Basic Texts Related to the Safety of Journalists*. Available at: <http://www.unesco.org/new/en/communication-and-information/freedom-of-expression/safety-of-journalists/basic-texts/>

UNESCO. 2015. *Safety guide for journalists. A handbook for reporters in high-risk environments*. Available at: <http://www.unesco.org/new/en/communication-and-information/resources/publications-and-communication-materials/publications/full-list/safety-guide-for-journalists/>

UNESCO. n.d. *UN Plan of Action on the Safety of Journalists and the Issue of Impunity*. Available at: <https://en.unesco.org/un-plan-action-safety-journalists>

В. БИЕ МАХБОДЫН БОЛОН СЭТГЭЛ САНААНЫ ЭРҮҮЛ МЭНД

Гэмтэж бэртэж болзошгүй даалгавар гүйцэтгэхэд та сэтгэл санааны бэлтгэлтэй байгаарай. Хамтран ажилладаг сэтгүүлчидтэй түүх, туршлагаасаа хуваалцаарай. Дарга, хамтрагч нараасаа асууж лавлах хэрэгтэй. Бие махбодын эрүүл мэндэд учирч болзошгүй аливаа эрсдэлд хянамгай хандаарай.

Г. ЦАХИМ АЮУЛГҮЙ БАЙДАЛ

- Гар тэмдэглэл, ном, гар утас болон компьютерын файл дотор мэдээллийн нууц эх сурвалж болох харилцагчийн нэрийг бүү хадгалаарай.
- Нууц, эрсдэлтэй эх сурвалжид кодоор нэр өгч, үүнийг гар тэмдэглэлдээ ашиглаарай.
- Гар утсаа нууцлал сайтай ПИН кодоор давхар хамгаалаарай.
- Нууц, эрсдэлтэй эх сурвалжийн холбоо барих хаягийг зохиомол нэрээр хадгалаарай.
- Нууц, эрсдэлтэй эх сурвалжийн дуудлагын бичлэгийг устгаарай.
- Текст зурвасаа устгаарай.
- Өөр форматаар нууц, эрсдэлтэй эх сурвалжийн дугаарыг нуугаарай.
- Цахим хуудсаар аялахад аюулгүй байдлыг хэрхэн хангах талаар олж мэдээрэй.
- Шифрлэгдсэн и-мэйл илгээх аргад суралцаарай.
- Нийгмийн сүлжээгээр нийтэлж буй зүйлд анхаарал тавиарай.

Д. ХАЛХАВЧИЛСАН СУРВАЛЖИЛГА

Сурвалжлагчид өөрсдөө хэн болох талаараа нээлттэй, илэн далангүй байх хэрэгтэй гэсэн сэтгүүл зүйн ерөнхий зарчим бий. Сурвалжлагчтай хуваалцдаггүй мэдээлэлд нэвтрэхийн тулд өөрийн хувийн мэдээлэл, үйл ажиллагааг нуун далдлахгүй байх хэрэгтэй.

Гэсэн ч тэр чигтээ “шилэн” байхын хэрээр гэмт хэрэг, нийгмийн эсрэг үйлдлийг нотлох баримтыг цуглуулах нь маш хэцүү байх болно.

Иймд гэмт хэрэг, эсвэл нийгмийн эсрэг ноцтой зан байдлыг магадлах олон нийтийн ашиг сонирхлыг хөндсөн зүй ёсны, бодитой шалтгаан байгаа үед зарим эрэн сурвалжлах сэтгүүлчид зохиомол хувийн мэдээлэл хэрэглэдэг бөгөөд тухайлбал ажиллагчдын эрх зөрчигддөг газарт ажилд орох гэж буй туршлагагүй ажилтны дүрд хувирах зэрэг болно. Үүнийг “халхавчилсан сурвалжилга” хийж, мэдээлэл цуглуулах гэдэг.

Хэрэв сурвалжлагч далдаар дуу хурааж, видео бичлэг хийвэл шүүх тэднийг хувийн нууцад халдсан, хууль бус гэж үзэж болно. Халхавчилсан сурвалжилга хийхдээ илчлэгдсэн сурвалжлагч заналхийлэл түүнчлэн бие махбодын хүчирхийлэлд ч өртөж болзошгүй юм.

Дараах асуултад анхаарал хандуулаарай:

- Та илчлэх гэж буй байгууллагадаа хэрхэн орох вэ?
- Та ганцаараа ажиллах уу?
- Та аюулгүй байдлаа яаж хангах вэ?
- Таны нууцлах мэдээлэл юу вэ?
- Хэт олон асуулт асуух, сэжиг төрүүлэхээс хэрхэн сэргийлэх вэ?
- Та мэдээллийг хэрхэн олж авах вэ?
- Хэрэв бүх зүйл буруудвал та үүнээс хэрхэн гарах вэ?

Аюулгүй байдал, нууцлал, эх сурвалжаа хамгаалах, эрэн сурвалжилга хийх алхмын талаар Монгол хэл дээр гарсан цөөн эх сурвалж байдаг. Эдгээрт дээрх нууцлал, аюулгүй байдлаа хангах алхмууд болон эрэн сурвалжилга хийх ур чадварын талаарх мэдээллүүд багтсан байдаг.

ЭХ СУРВАЛЖ

R.AGE. n.d. Student/Trafficked. Available at: <https://www.rage.com.my/trafficked/>

Fruit picking investigation Available at: <https://www.smh.com.au/interactive/2016/fruit-picking-investigation/>

Саөид Назакат, Эрэн сурвалжлах сэтгүүлчийн гарын авлага: Хэрхэн яаж ярианы гол сэдэв болох вэ? 2010. https://www.kas.de/c/document_library/get_file?uuid=2af1f415-40d2-786a-548e-8069f1bcb106&groupId=252038

Марк Ли Хантер, Эрэн сурвалжлах сэтгүүлчдэд зориулсан гарын авлага: Таамагт суурилсан судалгаа. 2011. <http://www.globeinter.org.mn/?cmd=Record&id=930&menuid=386>

Глоб Интернэшнл төв, Сэтгүүлчийн аюулгүй байдал: Гарын авлага, 2015. <https://www.globeinter.org.mn/images/upld/safetyofjournalists.pdf>

Хэвлэлийн хүрээлэн, НҮБ-ын Ардчиллын сан, Сэтгүүлчдэд зориулсан аюулгүй байдлын гарын авлага, 2022. <https://bit.ly/3iFt2nh>

3.3. ХЭСЭГ – “АМАН” ЭХ СУРВАЛЖ

Та ажиллагчид болон тэдний гэр бүл, ажил олгогчид, эсвэл агент, ажилд зуучлагчид, мөн эрдэм шинжилгээний ажилтнууд зэрэг олон төрлийн эх сурвалжаас мэдээлэл авах боломжтой юм.

Хэдийгээр тэд одоогийн нөхцөл байдалдаа дургүй ч энэ тухай нээлттэй ярих нь байдлыг дордуулж, аюулд оруулах ч эрсдэлтэй. Тэд таныг мэдээллээр хангаж буй учраас тэдэнд мэдрэмжтэй, хүндэтгэлтэй хандах хэрэгтэй байдаг.

Ажилд зуучлах, авах үйл явцын талаарх мэдээндээ ажил мэргэжлийн болон хувийн амьдралд нь хортой, ажиллагчдын санааг зовоодог олон янзын үр дагаварт хүргэдэг сайн, муу жишээг хөндөж болно.

Эдгээр мэдээг сурвалжилж буй сэтгүүлчид үнэн зөв, шударга, тэнцвэртэй мэдээлэх зарчмаар нотлох баримтыг бүрдүүлэхийн тулд болгоомжтой байж, мөн арга зүй сайтай ажиллах хэрэгтэй юм.

Олон эх сурвалжийг анзаарч үзэх хэрэгтэй. Дараагийн хэсэгт танд тодорхой төрлийн эх сурвалжтай хэрхэн ажиллах талаар зөвлөгөө өгнө.

А. ДАВАН ТУУЛАГЧ

Та тэдэнд шахалт үзүүлэх ёсгүй. Гэхдээ асуудлыг ярьснаар түүний цар хүрээ, мөн чанарыг олон нийтэд мэдээлнэ гэдгийг хохирогчдод хэлэх нь зөв юм. Ингэснээр бусдад ярих итгэл өгч болно. Энэ нь гадагш зорчих үед учирч болзошгүй аюулын талаар бусдад өгөх анхааруулга болно.

Хэрвээ та хэн нэгнээр сэтгэлийг нь шархлуулсан асуудал яриулахыг хүсэж байвал итгэлийг нь олох шаардлагатай.

Даван туулагч нь таны сурвалжилгад оролцсоноороо доромжлуулах, дахин хохирол амсахгүй гэдгийг тэд заавал мэдэх учиртай. Харин хүчирхийлэл, аймшигт хэргийн золиос болсон даван туулагчдын тухай таны сурвалжилга тухайн хүн тантай дахин уулзаж, дараа нь юу болсон талаар ярилцах эсэхийг тодорхойлно.

Хохирогчид, даван туулагч хүмүүс, түүнчлэн тэдний гэр бүлд үргэлж энэрэл, халамж, хүндэтгэл, нэр төртэй хандах хэрэгтэй. Энэ нь таныг үнэнийг олохын төлөө эргэлзэн эрэл хайгуул хийгч сэтгүүлч байхаа боль гэсэн үг биш юм.

Нөхцөл байдлаас шалтгаалан ярилцлага өгөх газрыг ярилцлага өгөх гэж буй хүнээр сонгуулахыг зөвлөж байна. Та тэднийг тав тухтай ярилцах боломжтой тэр газарт байлгах нь зүйтэй юм.

Хохирогчид болон даван туулагч хүмүүс өөрсдийг нь танигдахад хүргэж мэдэх аливаа мэдээллийг нийтлэхгүй байхыг танаас хүсэж болно. Хэвлэл мэдээллийн байгууллагууд баримт нотолгооны хүчийг сулруулах үр дагавартай байдаг тул нэрээ нууцалсан эх сурвалжуудыг ашиглахаас дандаа татгалздаг.

Буруутай этгээдүүд ярилцлага өгсөн хүмүүсийг шийтгэхээр оролдох аюул ч гарч болзошгүй. Сурвалжлагчид ийм зүйл тохиолдохгүй байх нөхцөлийг бүрдүүлэх нь маш чухал билээ.

Хэрэв та тэдний нэрийг нууцалж хамгаалахаа амласан бол үүнийгээ биелүүлэх ёстой. Тухайн хүний талаар маш их мэдээлэл нийтэлснээр түүнтэй ойр байгаа хэн нэгэн таныг хэний талаар ярьж буйг мэдэх боломжтой учраас тэднийг илчлэхгүй байхад анхаараарай.

Зарим маш эмзэг тохиолдолд нийтэлсэн бүтээлдээ нэр, хувийн мэдээллийг нь огт дурдахгүй байж болно. Дайсагнасан хүмүүсийн гарт орохоос сэргийлж та тэмдэглэл хөтлөхдөө тэдний хувийн мэдээллийг нууцлах хэрэгтэй.

Б. ДЭМЖИХ БҮЛГҮҮД, НӨЛӨӨЛЛИЙН БАЙГУУЛЛАГУУД, ЭРДЭМТЭН СУДЛААЧИД

Бүтээл хүний сэтгэлд хэр хүрч, нөлөөлөх нь тухайн асуудалд шууд хамаатай хүмүүсийн өгсөн мэдээллээс хамаардаг. Харин тухайн сэдвийн ерөнхий мэдээлэл дунд нэг, эсвэл түүнээс дээш хүний түүхийг оруулж өгөх нь бүтээлийг улам чамбайруулна.

Үүний тулд дараах салбар, байгууллагуудад ажилладаг мэргэжилтнүүдээс мэдээлэл авна уу.

- Хохирогчид болон даван туулагч хүмүүсийг дэмжих бүлэг
- Холбоод
- Үйлдвэрчний эвлэлүүд
- Хууль сахиулах байгууллагууд
- Нийгмийн үйлчилгээ болон бусад төрийн үйлчилгээ
- Эрдэмтэд
- Асуудалд мэргэжлийн ашиг сонирхлын үүднээс хандаж буй улс төрчид
- Хуульчид
- Олон улсын хөдөлмөрийн байгууллага зэрэг олон улсын байгууллагууд.

Тэдэнтэй уулзахдаа ярилцлага авч болох бусад хүмүүсийг санал болгохыг гуйгаарай. Сүлжээ, харилцаагаа өргөжүүлээрэй. Тэднийг нийгмийн сүлжээнд дагаж, хэвлүүлсэн өгүүллийг нь уншаарай.

Сурвалжлах түүхээ судалж байхдаа хүн бүрийн хэлж буй зүйлийг нарийвчлан тэмдэглэж авахаа мартаузаарай. Хэрэв та нийтлэлээ бичих үедээ түүнийгээ бүрэн ойлгосон эсэхэд эргэлзэж байгаа бол эргэн очиж, зөв хүнээсээ нягталж асуух боломжтой. Мөн та зөв хүмүүст нь үзэл бодлоо хүргэх боломжийг олгож болох ч эсрэгээрээ алдаатай мэдээлэл иш татаж, буруу санаа бодлыг тусгавал хүмүүсийн итгэлийг алдаж ч болно.

В. ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧИЛД БУРУУТГАГДАЖ БУЙ ХҮМҮҮС

Гэмт хэрэг үйлдсэн болон нийгэмд тогтсон хэм хэмжээг зөрчсөн хэмээн буруутгагдаж байгаа хүмүүсийн талаар хангалттай баримт мэдээлэл бүрэн цуглуулсны дараа хамгийн сүүлд тэдэнтэй холбоо барьж, тайлбар авах ёстой.

Хэрэв та тэдэнтэй хэт эрт холбоо баривал гэрчүүдийг дарамталж, нотлох баримтыг устгах зэргээр таны эрэн сурвалжилгыг амжилтгүй болгох эрсдэлтэй байдаг.

Гэсэн ч шударга, тэнцвэрт байдлыг хангах үүднээс хэн нэгнийг буруутгасан аливаа баримт мэдээлэлд зохих хариу өгөх боломжийг заавал олгох хэрэгтэй.

Хэвлэл мэдээллийн олон байгууллагууд буруутгагдаж байгаа хүмүүс хариулт өгөхөд нэгээс хоёр өдөр хангалттай гэж үздэг. Харин энэ нь тэдний хувьд

хуулийн дагуу болон хууль бусаар ч бай аль аль нь хэвлэн нийтлэхийг зогсоох арга хэмжээ авахад хангалттай хугацаа биш юм.

Хэрэв тэд уулзахыг зөвшөөрвөл өөрийнхөө аюулгүй байдлыг анхаарч үзээрэй.

- Хамт ажилладаг хүнтэйгээ цуг яваарай.
- Хаашаа явж байгаагаа редактортаа мэдэгдээрэй.
- Таныг анхаарч, шалгах хүнтэй яриарай.
- Дэлгэрэнгүй тэмдэглэл эсвэл бичлэг хийгээрэй.
- Ярилцлагыг мэргэжлийн, соёлтой явуулаарай.
- Уурлаж, эгдүүцсэн байдал бүү гаргаарай.

Хэрэв тэд уулзахаас татгалзвал та тэднээс утсаар болон и-мэйлээр асуултад хариулахыг хүсэж болно.

Гурав дахь сонголт нь тэдний эсрэг гаргасан мэдээллийн хариу, тайлбар болгон ашиглах мэдэгдлийг өөрсдөөр нь бичгээр болон бичлэг хийлгэн авч болно.

Та хариу авахыг тууштай эрмэлзэж, үнэн зөв, шударга байдлын үүднээс үйл явдлын талаар тэдний үзэл бодлыг сонсохыг хүсэж байгаагаа давтаж хэлэх хэрэгтэй.

Хэрэв та дахин дахин оролдоод ч хариу өгөхгүй бол олон нийтэд нээлттэй бусад эх сурвалжийг ашиглан тэдний байр суурийг чадах чинээгээр гаргахыг хичээх хэрэгтэй. Тэгээд та түүнийгээ дараа нь өөрийнхөө үгээр бичиж болно.

Үргэлж эелдэг байгаарай. Сэтгүүлчийн хувьд та шүүж, гэм бурууг тогтоох биш харин олон нийт өөрсдөө дүгнэлт хийж чадах хэмжээнд хүртэл аль болох сайн баримтжуулах, мэдээлэх үүрэгтэй байна.

МОДУЛЬ 4

ҮЙЛ ЯВДЛЫГ ӨГҮҮЛЭХ НЬ



4.1. ХЭСЭГ - ЯМАР ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЛИЙГ СОНГОХ ВЭ?

Хэвлэн нийтлэх олон тооны платформ сэтгүүлчдэд бий. Бүтээлээ олон хүнд хүргэж, хамгийн их үр нөлөө үзүүлэхэд ашиглаж болох арга хэрэгслийн талаар эртнээс бодож үзэх нь зөв юм.

Та зөвхөн нэгийг нь сонгох хэрэггүй. Сонин, цахим сайт, телевиз зэрэг өөр өөр платформд бүтээлээ янз бүрийн хэлбэрээр нийтэлж, нэвтрүүлж болно.

А. ЦАХИМ САЙТ

Хэвлэл мэдээллийн бүх хэрэгслүүд нь цахим сайттай бол зарим нь зөвхөн мэдээллийн цахим сайт хэлбэрээр ажилладаг. Гэсэн ч эдгээр цахим сайт нь текст, зураг түгээдэгтэйгээ адилхан видео, аудио сурвалжилгыг хялбархан нийтэлж чадна. Сурвалжилга, нэвтрүүлгээ бүтээх явцдаа нийтлэл дотор болон хажууд нь нийтлэх боломжтой гэрэл зураг, аудио, видео бичлэгийн талаар анхаарах хэрэгтэй.

Зураг, инфографик, газрын зураг, аудио, видео клип зэрэг дүрслэлийн элементийг урт текстэй өгүүлэлд оруулсан цахим нийтлэлийн шинэ хэлбэрийг “урт бичвэр” гэж нэрлэдэг. Энэ хослол нь нийтлэлийн форматыг маш сонирхолтой болгодог. Ялангуяа сонин сэтгүүлийн бүрэн хэмжээний болон эрэн сурвалжлах нийтлэлд илүү тохиромжтой байдаг.

Б. НИЙГМИЙН СҮЛЖЭЭ

Хэвлэл мэдээллийн байгууллагуудын олонхи нь Фэйсбүүк, Твитэр, Инстаграм зэрэг нийгмийн сүлжээний хэрэгслийг өргөнөөр ашигладаг. Ихэнхдээ нийгмийн сүлжээг үзэгчдийг татах, хандалт нэмэх арга зам гэж үздэг ч тэдгээрийг бүтээл нийтэлж, нэвтрүүлэхэд мөн адил ашиглаж болно.

Зарим сурвалжлагчид твитэрт урт ярвигтай мэдээг өгүүлэхдээ ухаалаг аргуудыг хэрэглэдэг байна. Тухайлбал цуврал жиргээгээр 2, 3 өгүүлбэрээс хэтрэхгүй богино зурвас түгээж, түүндээ ихэвчлэн зураг эсвэл богино дүрс бичлэг дагалдуулна.

Инстаграмаар зураг, богино видеог хуваалцахад тохиромжтой. Мэдээжээр ярилцлага өгсөн хүмүүсийн зургийг тэдний зөвшөөрөлтэй цувралаар нийтлэх боломжтой.

Ялангуяа таны мэдээнд дурдагдаж буй хүн эсвэл байгууллагаас тодорхой хариу үйлдэл хүсэж байгаа үед нийгмийн сүлжээний агшин зуурын шинж чанар нь нэлээд хүчтэй нөлөө үзүүлдэг. Твитэр ашиглан төрийн эрх мэдэлтнүүдэд нөхцөл байдлыг ойлгуулснаар тэдний зүгээс хурдан шуурхай арга хэмжээ авч, албадан хөдөлмөр, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод хэрхэн тусалж болохыг сүүлийн үеийн жишээнүүд харуулж байна.

Гэсэн ч нийгмийн сүлжээг ёс зүйтэй, ёс зүйгүй ажилд зуучлагч нар ашиглаж, ажиллуулдаг тул албадан хөдөлмөр болон ажилд зуучлах, авах харилцаанд шударга зохистой ажиллагааны аль алинд хүргэдэг орчин гэж үзэх нь зүйтэй юм. Олон хүн нийгмийн сүлжээгээр ажлын байраа хайж байгаа нь эдгээр платформд чанартай сурвалжилга нийтлэх ёстой гэсэн санааг бататгаж өгдөг.

В. РАДИО ХӨТӨЛБӨР

Радио хөтөлбөр тогтмол цагийн хуваарийн дагуу, эсвэл бүхэлдээ хүссэн үедээ татаж авч, тоглуулж болохуйц подкаст хэлбэртэй байж болно. Дууны эх үүсвэртэй ойр болон нэмэлт микрофон хэрэглэх боломжтой үед гар утсаар бичлэг хийхэд сайн төхөөрөмж болдог. Мөн засвараа гар утас, компьютер дээр хийж болно.

Г. ВИДЕО

Ухаалаг гар утас дээр дүрс бичлэг хийх, цаашлаад засварлах зэрэг энгийн видео бүтээх техникүүд нь техник нөөц багатай хүмүүст өөрсдийн видео бүтээлийг хийх боломж олгодог бөгөөд цахимаар түгээх, телевизээр нэвтрүүлэх, кино театр, олон нийтийн танхимд үзэгчдэд толилуулах боломжтой юм.

Д. АНИМЭЙШН

Оролцсон хүмүүсийн хувийн мэдээллийг хамгаалах шаардлагатай тохиолдолд анимэйшн нь түүхийг өгүүлэх шилдэг арга болно.

Е. АППЛИКЭЙШН

Хүмүүсийн олонхи нь хэвлэл мэдээллийн байгууллагуудаас санал болгодог аппликэйшнийг хэрэглэж, контентуудтай нь танилцах боломжтой байдаг. Харин аппликэйшн ашиглаж шинэ арга хэлбэрээр нийтэлж, нэвтрүүлэх туршилт нь аль эртнээс эхэлсэн байна. Тухайлбал “Би Би Си” өөр улсад ажил хийж, ирээдүйгээ хайхаар амьдралаа эрсдэлд оруулсан нэгэн цагаачид тохиолдсон явдлыг харуулсан видео бүтээжээ.

Ё. ҮЙЛ ЯВДЛЫГ ЗУРГААР ӨГҮҮЛЭХ НЬ

Өмнөх бүлэгт дурдсанчлан сэтгүүлчид хөдөлмөрийн асуудлаар бичихдээ сэдвээ хэрхэн дүрслэх талаар сайтар бодох хэрэгтэй. Эх сурвалжийн нэрийг нууцлах, хөдөлмөрлөх эрхийн зөрчлийн хохирогчийг хамгаалахад онцгой анхаарал хандуулах нь зүйтэй юм.

4.2. ХЭСЭГ- ЦУВРАЛ БҮТЭЭЛ БЭЛТГЭХ НЬ

Хэрэв та албадан хөдөлмөр болон ажилд зуучлах, авах харилцаанд шударга байдлыг хангах зэрэг хүнд хэцүү сэдвээр шаргуу хөөцөлдөж байгаа үед нэг удаагийн мэдээ, сурвалжилгад багтахгүй их материалтай болох магадлалтай. Энэ тохиолдолд та ижил сэдвээр цуврал бүтээл бэлтгэж, цахим сайтад байршуулах боломжтой.

ЖИШЭЭ

IFJ. n.d. Stop violence against women journalists. Available at: <https://www.ifj.org/actions/ifj-campaigns/stop-violence-against-women-journalists.html>

Independent. n.d. Slaves on our streets. Available at: <https://www.independent.co.uk/topic/slaves-on-our-streets>

Та дараагийнхаа алхмыг цуврал бүтээлээр кампанит ажил болгох талаар бодож болно. Энэ нь хэвлэл мэдээллийн байгууллага асуудлыг төвийг сахисан байдлаар мэдээлэх хэвшмэл үүргээсээ цаашилж, бодлогын өөрчлөлтийг дэмжих тал дээр бодитой анхаарч буйн жишээ юм. Шударга, бодитой байхыг зорьж буй мэдээ, хэвлэл мэдээллийн хэрэгслүүд нь гэмт хэрэгтэй тэмцэх, хүний эрх, эрх чөлөөг тэр дундаа эрүүл мэнд, ажил хөдөлмөр чөлөөтэй эрхлэх эрхийг дээдлэх талаар ойлголтыг сурталчлан таниулж байдаг.

Кампанит ажлын цуврал бүтээлийг нэг хувь хүний түүх дээр төвлөрүүлж, тодорхой хугацаатай нэвтрүүлэх, эсвэл ижил асуудалтай нүүр тулсан өөр өөр хүнийг оролцуулж, эсвэл нэг асуудлыг хэд хэдэн өнцгөөс авч үзэж болно. Тухайбал хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн болон эрх нь зөрчигдсөн ажилтан, ажил олгогч, агент, хууль сахиулах байгууллагын ажилтан зэрэг болно.

Бүтээлийг олон өдөр дараалуулж, эсвэл үе үе цуврал хэлбэрээр нийтэлж, нэвтрүүлж болно. Удаагүй гарах дараагийн бүтээлийг сануулж пост оруулах нь үзэгчид, уншигчдыг татахад тусална.

- “Маргаашийн цувралаар Абдулыг амь өрсөн аялалд явуулсан брокертой уулзах болно.”
- “Бид Маригаас илүү ихийг сонсож, эрх чөлөөт эмэгтэйн амьдралаар хэрхэн замнаж буйг олж мэдэх болно.” гэх мэт.

ЦУВРАЛ БҮТЭЭЛЭЭР КАМПАНИТ АЖЛЫГ АМЖИЛТАД ХҮРГЭХ ЗУРГААН АЛХАМ

АЛХАМ 1: ЗОРИЛГОО ТОДОРХОЙЛОХ

Компанит ажил том зүйлээс эхэлж, эсвэл жижиг зүйлээс эхлээд аяндаа томорч болно. Урьдчилж сайтар төлөвлөх нь үргэлж үр дүнгээ өгдөг билээ. Таны зорилго эхнээсээ тодорхой байх ёстой. Та бүтээлээрээ хуульд өөрчлөлт оруулахыг уриалж байна уу? Эсвэл өөр үйл ажиллагаа, үйлдэлд уриалах уу? Тухайлбал:

- “Зөвшөөрлийн системийг зогсоох хүртэл бид компанит ажлаа үргэлжлүүлнэ.”
- “Хүний наймаанд өртсөн бүх эмэгтэйчүүдийг чөлөөлж, төрөөс анхаарал халамж тавих ёстой.”

АЛХАМ 2: КАМПАНИТ АЖЛЫГ УДИРДАХ

Эрч хүчээ алдахгүй ажлаа явуулахын тулд нэг хүн компанит ажлыг өдөр тутамд удирдан зохицуулж байх хэрэгтэй. Энэ нь ихэвчлэн бүтээлийн дийлэнхийг бичиж, бэлтгэж буй сурвалжлагч байх болно.

Компанит ажилд мөн редакцын багт ахлах албан тушаалтай орлогч редактор, мэдээний албаны дарга, эсвэл ижил алба эрхэлдэг хүн манлайлагчаар оролцох хэрэгтэй.

Манлайлагч нь цаг хугацаа болон бусад нөөцийн хуваарилалтыг хариуцна. Компанит ажилд олон эх үүсвэр шаардлагатай бөгөөд гүйцэтгэх ажилтнуудад тэднийг хариуцуулбал удаашралтай байж мэднэ. Манлайлагч нь мөн сурвалжилгатай холбоотойгоор талуудаас үзүүлэх дарамт шахалтыг зохицуулж бичвэр хариуцсан багийг хамгаална.

АЛХАМ 3: ЭХЛЭХДЭЭ ХҮЧТЭЙ СЭТГЭГДЭЛ ТӨРҮҮЛЭХИЙГ ЭРМЭЛЗЭХ

Компанит ажлыг үр нөлөөтэй эхлүүлэхийг хичээгээрэй. Мөн төлөвлөсөн өөр нэг үйл явдалтай давхцахгүй өдрийг сонгох хэрэгтэй.

Эхний компанит ажлын мэдээг нэр хүндтэй сонины нүүр хуудаст, эсвэл телевиз, радиогийн мэдээллийн тойм дээр байршуулаарай. Үүнийгээ хөндлөнгийн мэдээ, байр суурь, гэрэл зураг болон инфографикаар дэмжээрэй.

АЛХАМ 4: УНШИГЧИД ОРОЛЦОХОД ХЯЛБАР БОЛГОХ

Хүмүүс нийгмийн сүлжээгээр маргаантай асуудлаар үг хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх нь нэмэгдэж байна. Иймд хэлэлцүүлгийг олон хийж, үзэгч, уншигчдыг татан оролцуулаарай. Цахим сайтад сэтгэгдэл бичих боломжтой болгож, хамгийн сонирхолтой, дэмжүүштэй сэтгэгдлийг сонгож нийтлээрэй. Гэвч сөрөг, арьс өнгө, хүйсээр ялгаварласан зэрэг сэтгэгдэл байж болзошгүйг анхаарна уу. Иймд цахим сэтгэгдэлд тодорхой, хатуу журам мөрдүүлэх нь чухал юм.

Сэтгэгдэл, цаашлаад мэдээлэл, эсвэл бүтээлийн санаа болохуйц зүйлсийг олон нийтээс хүлээж авах тусгай и-мэйл ажиллуулаарай.

Хуульд өөрчлөлт оруулах гэх мэт тодорхой арга хэмжээ авах шаардлагыг иргэд дэмжиж гарын үсэг зурж, оролцдог платформ бий. Хэрэв ийм боломжтой бол шаардлагаа байршуулах, эсвэл уг асуудлыг дэмжиж буй улс төрчийг оролцуулаарай. Дараа нь уншигч, үзэгчдийг шаардлагад гарын үсэг зурахыг уриалаарай. Гарын үсгийн тоо өсөн нэмэгдэж буйг нийтлэх нь компанит ажилд дэмжлэг нэмэгдэж байгааг харуулна.

АЛХАМ 5: УНШИГЧДЫН ХИЙЖ ЧАДАХГҮЙ ЗҮЙЛСИЙГ ХИЙХ

Хэвлэл мэдээллийн байгууллагынхаа хүч чадал, хэр хэмжээг санаарай. Уншигчдын дуу хоолойг нэмэгдүүлж, эрх мэдэлтнүүдээс хариуцлагыг нэхэж, хариулт шаардах боломжтой.

Бүтээл хүрч, уншигдсан эсэх, мөн таны баримт сэлттэй холбоотой ямар нэгэн тайлбар байгаа эсэхийг мэдэхийн тулд хариулт, шахалтаа үргэлжлүүлээрэй. Хэрэв тэд ямар нэгэн тайлбар, мэдээлэл хэлэхгүй байвал долоо хоногийн дараа, мөн түүний дараагийн долоо хоногийн дараа дахин хандаж үзээрэй. Хариулт авахаар гаргасан оролдлого бүртээ тэмдэглэл үйлдээд энэ талаар өгүүлэлдээ нийтлээрэй.

АЛХАМ 6: ЗОГСОЛТГҮЙ ҮРГЭЛЖЛҮҮЛЭХ

“Та ямар нэг кампанит ажлыг үргэлжлүүлсээр туйлдаж эхлэх үед уншигчид дөнгөж л анзаарч эхэлдэг” гэсэн хуучны үг сонины сэтгүүлчдийн дунд яригддаг. Хэрэв та маш богино хугацаанд зоримог кампанит ажил хийхээр сонгоогүй л бол урт удаан хугацаанд үргэлжилж болзошгүй юм. Кампанит ажлыг амьд, идэвхтэй, сонирхолтой байлгах нь шууд хариуцдаг цөөн хэдэн хүний үүрэг бус нийт редакцын ажил болох ёстой билээ.

4.3. ХЭСЭГ – ТА БЭЛЭН ҮҮ?**А. РЕДАКТОРЛАХ ҮЙЛ ЯВЦ**

Бусад сурвалжилгатай нэгэн адил албадан хөдөлмөр болон ажилд зуучлах, авах харилцаанд шударга байдлыг хангах талаар сурвалжлахдаа редакторын сайн удирдамж практикийг хэрэглэх шаардлагатай. Сэдэв бүрээр редакторлах үйл явцад ашиглах олон эх сурвалж байдаг бөгөөд сайн туршлагууд арвин тул энэ гарын авлагад бүгдийг дурдах боломжгүй юм.

Б. ТА БЭЛЭН ҮҮ?

Та мэдээ, эсвэл цуврал бүтээлээ хэвлэхээс өмнө оролцсон бүх хүний мэдээлэл багтсан эсэхийг нягтлаарай. Та дараах асуултад тодорхой хариулт өгөх ёстой.

- Та юуг хэлж, нотлох гэж оролдож байна вэ?
- Үүнийг хэлэх хангалттай мэдээлэл, нотлох баримт байгаа юу?
- Таны мэдэгдэл, тайлбарт ямар шууд бус дүгнэлт агуулагдаж байгаа вэ?
- Та өөрийн эх сурвалж, баримт бичгийн дүн шинжилгээнд бүрэн итгэлтэй байна уу?
- Та бүх баримт мэдээлэлээ шалгаж, нягтлахад нэмэлт хүчин чармайлт гаргасан уу?
- Шүүмжлүүлж буй бүх хүмүүст тайлбар өгөх боломж олгосон уу?
- Сэтгүүл зүйн бүтээлийн бүтэц юу вэ? Эхлэл, дунд, төгсгөл дээрээ ажиллаарай.
- Та бүтээлийг хялбар ойлгож болох хэсгүүдэд хуваах боломжтой юу?
- Та сурвалжилгаа хэрхэн дүрсжүүлэх вэ? Та мэдээгээ зураг, чимэглэл, хүснэгт, график ашиглан баяжуулж чадах уу?
- Хуульч, эсвэл туршлагатай редактор бүх мэдээг (мөн гарчигийг нь) шалгасан уу?

Хэрэв та эдгээр асуултад бүрэн хариулж чадахгүй байгаа бол хэвлэхэд бэлэн биш байна.

МОДУЛЬ 5

БҮТЭЭЛИЙН ҮР ДҮНГ ҮЗЭХ НЬ



5.1. ХЭСЭГ – ҮР НӨЛӨӨ, ШАГНАЛ БОЛОН МЭРГЭШСЭН БАЙДАЛ

А. ҮР НӨЛӨӨ

Сайн сэтгүүл зүй хүмүүсийн амьдралд өөрчлөлт авчирдаг.

Сурвалжилж буй үйл явдал дуусахгүй байж магадгүй гэхдээ таны нийтэлж буй сурвалжилга нь:

- Хувь хүн болон хүмүүсийг албадан хөдөлмөрөөс чөлөөлөхөд хүргэж болно.
- Ажил олгогчийг дадал хэвшлээ өөрчлөх, эсвэл бизнесийн түншүүддээ ч мөн адил зүйл хийхийг уриалахад хүргэж болно.
- Эрх нь зөрчигдсөн ажиллагчдад итгэл найдвар өгч, бусдад туслах бүлгийг байгуулах хэлхээ холбоог бий болгоно.
- Хууль тогтоомжийг боловсронгуй болгож, одоо мөрдөж байгаа хуулиудыг хэрэгжүүлэхийг эрх мэдэлтнүүдэд уриална.
- Албадан хөдөлмөр болон ажилд зуучлах, авах харилцаанд шударга бус хандах явдал, тэдгээрийн үндсэн шалтгааныг шийдвэрлэхэд бодлого боловсруулагчдыг уриална.
- Тодорхой төрлийн ажиллагчдын нөхцөл байдлын талаарх мэдлэг, ойлголтыг дээшлүүлж, олон нийтийн буруу ойлголтыг өөрчилнө.

Ажиллагчдад тааламжтай үр дүн бий болгоход анхаарах нь нэн чухал билээ. Албадан хөдөлмөрийн нөхцөл байдлын талаар сурвалжлахдаа албадан хөдөлмөрөөс ангижрах шийдлийг олох нь зорьж буй гол үр дүн болно. Харин зохистой хөдөлмөрийн нөхцөл бүрдээгүй бусад асуудлыг хөндөх тохиолдолд зорьж буй гол үр дүн нь нарийн тодорхой биш байхын зэрэгцээ олон талын оролцоотойгоор томоохон өөрчлөлт хийх замаар хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулахад чиглэх тул хэрэгжилт болон түүний мөрөөр хяналт тавихад хэцүү байж магадгүй юм.

Б. ШАГНАЛ

Бараг бүх төрлийн сурвалжилгад зориулсан шагнал, урамшуулал, тэтгэлэг байдаг. Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөн, тэр дундаа албадан хөдөлмөрийн асуудлыг шуурхай эрэн сурвалжилж гаргаж ирсэн бол хэвлэл мэдээллийн үндсэн шагналууд дотор ялгарч чаддаг. Сүүлийн жилүүдэд улс орнууд хамгийн нэр хүндтэй шагналаа энэ төрлийн мэдээнд олгож байна.

- Pulitzer prize (USA): Seafood from slave (2016)³⁵
- National Magazine Award (Canada): The Cage (2016)
- Albert Londres (France): Voyage en barbarie (2015)³⁶

Бусад хэвлэл мэдээллийн байгууллагуудын анхаарлыг уг асуудалд төвлөрүүлж, тухайн үедээ олон нийтийн анхаарлыг татдаг тул эдгээр онцлог байдал нь мэдээний анхдагч үр нөлөөг нэмэгдүүлэхэд тусална.

Хөдөлмөр, шилжилт хөдөлгөөний асуудалд анхаарал хандуулсан хэд хэдэн шагнал байна.

³⁵ AP. [An AP investigation helps free slaves in the 21st century](#), 2016.

³⁶ Voyage en Barbarie. n.d. [Accueil](#).

- Global media competition on labour migration and fair recruitment³⁷
- Migration Media Award³⁸
- Anti-Slavery Day Awards³⁹
- ILCA Labor Media Awards⁴⁰
- International Women in Media Foundations Awards⁴¹

В. МЭРГЭШСЭН БАЙДАЛ

Мэргэшсэн ур чадвартай сэтгүүлчдийг заримдаа “товшигч” сурвалжлагч гэж нэрлэх тохиолдол байна. Учир нь тэд тусгайлсан товшилт хийдэг. Мэдээний редакц ч гэсэн тодорхой асуудлаар мэргэшсэн сэтгүүлчдийн үр шимийг хүртэнэ. Албадан хөдөлмөр болон ажилд зуучлах, авах харилцаанд шударга байдлыг хангах талаар мэргэшсэнээр та дараах зүйлсийг хийж чадна.

- Шууд сурвалжлах боломжгүй ч гэсэн мэдээний редакцад дагнасан нийтлэл, нэвтрүүлэг бэлтгэх талаар санал болгох
- Нарийн төвөгтэй мэдээллийг ойлгох, тайлбарлах
- Ярилцаж, мэдээллээр хангах боломжтой олон мэргэжилтнүүдийг мэддэг болох
- Хамтрагч нартаа холбоотой мэдээ бэлтгэхэд нь туслах
- Бүтээлтэй зэрэг түгээх “ерөнхий суурь” мэдээллийг бэлтгэх, агуулгыг нь тайлбарлах
- Удахгүй болох шинэ үйл явдлуудыг угтан урьдчилан төлөвлөх, тэдгээрийг сурвалжлахад мэдээний редакцаа бэлэн байлгах.

Хэрэв та мэргэшвэл таны ажил илүү сонирхолтой, урам зоригтой болно.

- Та тухайн сэдвийг сайн мэддэг болно.
- Олон жилийн турш нийтлэг бүтээл бэлтгэсний дараа шинэ сорилт авчрах ажлын шинэ арга барилтай болно.
- Та олон нийтийн дунд болон ажил дээрээ хүлээн зөвшөөрөгдсөн сайн нэр хүндтэй болно.
- Аль сэдвээр нийтлэл, нэвтрүүлгийг хэрхэн бэлтгэхээ шийдэхдээ илүү эрх чөлөөтэй болно.
- Та шальдар булдар, урьдчилж дүгнэж болох үйл явдлыг сурвалжлагаас зайлсхийх боломжтой болно.
- Танд илүү ахлах түвшний ажил албыг авчирч мэдэх авьяас чадвараа харуулах боломжтой болно.

³⁷ ILO, [ILO launches 2018 global media competition on labour migration and fair recruitment](#), 14 September 2018.

³⁸ Migration Media Award. <http://www.migration-media-award.eu>

³⁹ Human trafficking foundation. [Anti-slavery day awards](#), 2018.

⁴⁰ ILCA. [Inspiration](#), 2018.

⁴¹ International Women in Media Foundations Awards. [Our awards](#).

5.2. ХЭСЭГ - СҮҮЛИЙН ЗӨВЛӨМЖ

А. БАЙНГА УНШИХ

Та хэвлэлийн хуудас болон эфирт нэвтрүүлж буй зүйлсээсээ ч илүү ихийг мэддэг байх ёстой.

Тухайн сэдвийнхээ талаар чадах бүхнээ уншаарай. Мэргэжлийн сэтгүүл уншаарай. Холбогдох блогуудыг дагаарай. Төрийн болон төрийн бус байгууллагууд өөрсдийн үйл ажиллагааны талаарх мэдээллийн товхимлуудыг байнга гаргадаг.

Ажилд авах механизм хэрхэн ажилладаг, ажиллах хүчний шилжилт хөдөлгөөн гэж юу болох, олон улсын болон үндэсний эрх зүйн зохицуулалт хэрхэн хүчин төгөлдөр болдог зэргийг ойлгох хэрэгтэй.

Сонгож авсан сэдвийнхээ талаар албан ёсоор суралцах, семинарт оролцох боломж гарвал ашиглаарай. Боломж бүр мэдлэгээ тэлж, сүлжээгээ өргөжүүлэхэд тусалдаг гэдгийг санаарай.

ЭХ СУРВАЛЖ

Ажилд зуучлах, авах харилцаанд шударга байдлыг хангах талаарх Олон улсын хөдөлмөрийн байгууллагын сэдэвчилсэн цахим хуудас: www.ilo.org/fairrecruitment

Албадан хөдөлмөрийн талаарх Олон улсын хөдөлмөрийн байгууллагын сэдэвчилсэн цахим хуудас: www.ilo.org/forcedlabour

Thomson Reuters Foundation n.d. Human trafficking and modern day slavery reporting human trafficking and modern day slavery, available at: <https://www.trust.org/media-development/programmes/?sfid=a15D0000018xNlAlAM&areaOfFocus=Human%20Trafficking%20and%20Modern%20Day%20Slavery>

Б. СЭДВИЙН АГУУЛГА ДОТРОО ТӨӨРЧ БОЛОХГҮЙ


Таны ажил бол мэргэжлийн бус жирийн иргэд, сонсогчдод мэргэжилтний хэмжээнд ойлгох агуулгыг энгийнээр тайлбарлах явдал юм. Үүнийгээ тодорхой тайлбарлах нь таны үүрэг. Энэ нь:

- Мэргэжлийн үг хэллэгийг өдөр тутмын хэлнээ буулгах
- Хамааралгүй мэдээллийг тасалж, авах
- Тодорхой бус зүйлийг тодруулж, тайлбарлах
- Мэдээгээ уншигч, сонсогч, үзэгчдэд ач холбогдолтой болгох.


В. ГАНЦААРАА БҮҮ БАЙ


Ижил төсөөтэй, хүнд хэцүү асуудлыг сурвалжилж буй сэтгүүлчидтэй холбоотой байгаарай. Тэд танд зарим мэдээлэл, зөвөлгөө, холбоо барих хаяг, нийтлэл бичих санаа зэргийг өгч болох юм. Орон нутагтаа өөрийн хүрээлэл, эсвэл хааяа цугладаг албан бус бүлгэм бий болгох, гишүүн нь болох санааг бодолцож үзээрэй.

ОЛОН УЛСЫН ХӨДӨЛМӨРИЙН БАЙГУУЛЛАГА


 Монгол Улс, Улаанбаатар-14201, Сүхбаатар дүүрэг,
Нэгдсэн Үндэстний гудамж 12, НҮБ-ын байр

 www.ilo.org/mongolia

 ulaanbaatar@ilo.org


 (976) 11-320624

МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИСС


 Монгол улс, Улаанбаатар хот-15170, Чингэлтэй дүүрэг,
Барилгачдын талбай-2, Засгийн газрын 12 дугаар байр

 nhrcm.gov.mn

 info@nhrcm.gov.mn

 (976) 7000-0222

ISBN 978922040287-0



9 789220 402870